



# УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

*/Орон нутгийн иргэд, эмэгтэйчүүдэд зориулав/*

Улаанбаатар  
2020 он

## УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

---

Боловсруулсан:	Хил Хязгааргүй Алхам ТББ
Хэвлэлийн дизайнер:	Г.Ганчимэг
Гэрэл зураг:	МОНЭС, Хил Хязгааргүй Алхам ТББ
Хэвлэлийн хуудас:	6хх
Хэвлэсэн хувь:	500ш
Хэвлэсэн газар:	«Гал билэг» ХХК

# ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ.....	4
НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР.....	5
ӨМНӨХ ҮГ.....	7



## **Нэгдүгээр бүлэг. АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ..... 11**

1.1. Хайгуулын тусгай зөвшөөрөл .....	12
1.2. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох дараалал .....	14
1.3. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг .....	15
1.4. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бичиг баримтад хяналт хийх карт.....	19
1.5. Хайгуулын шатанд иргэний оролцоо .....	21
1.6. Хайгуулын шатанд талуудын хамтын ажиллагаа .....	24



## **Хоёрдугаар бүлэг. АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ .....27**

2.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл .....	28
2.2. Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох дараалал .....	30
2.3. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг .....	32

2.4. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт хийх карт.....	40
2.5. Ашиглалтын шатанд иргэдийн оролцоо.....	41
2.6. Ашиглалтын шатанд талуудын хамтын ажиллагаа .....	44



## **Гуравдугаар бүлэг. ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ ..... 47**

3.1. Хүний үнэ цэнэ.....	48
3.2. Хүний эрх, эрх чөлөө.....	49
3.3. Хүний эрхийн хамгаалалт.....	50
3.4. Эмэгтэйчүүдийн эрх .....	51



## **Дөрөвдүгээр бүлэг. МАНЛАЙЛАГЧДЫН ТҮҮХ .....61**

4.1. Дорноговь аймгийн Айраг сумын малчин эмэгтэй.....	62
4.2. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Тост багийн ногоочин эмэгтэй .....	64
4.3. Завхан аймгийн Дөрвөлжин сумын Цогт багийн туршлага .....	65

ХАВСРАЛТ.....	66
---------------	----

АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	72
-------------------------	----

## ТОВЧИЛСОН ҮГ

ААНБ Аж ахуйн нэгж байгууллага

АХЖЭ- Ашиг хүртэгч жинхэнэ эзэн

БОНБҮ- Байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль

БОННҮ- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

БОМТ- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

ИНБ- Иргэний нийгмийн байгууллага

ТББ- Төрийн бус байгууллага

БИНХ- Багийн иргэдийн Нийтийн хурал

ИТХ- Иргэдийн төлөөлөгчдийн хурал

МХЕГ- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

АМГТГ- Ашигт малтмал,газрын тосны газар

БОАЖЯ- Байгаль орчин аялал жуулчлалын яам

АБОАЖГ- Аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газар

БОХ- Байгаль орчныг хамгаалах

ЗД- Засаг дарга

## НЭР ТОМЪЁНЫ ТАЙЛБАР

**“ашигт малтмал”** гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд үүсч бий болсон, аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдсийн хуримтлалыг;

**“ашигт малтмал эрэх”** гэж ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайд эрдсийн хуримтлал байгаа эсэхийг тогтоох зорилгоор хийгдэж байгаа геологийн судалгааны ажлыг;

**“ашигт малтмал хайх”** гэж эрдсийн хуримтлалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, түүний нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийхийг;

**“ашигт малтмал ашиглах”** гэж газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг;

**“уурхайн талбай”** гэж энэ хуулийн 4.1.16-д заасан тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг;

**“уурхайн эдэлбэр”** гэж уурхайн талбайтай давхацсан, ашигт малтмал олборлох геологийн тогтоцын хэсгийг;

**“бичил уурхай эрхлэх”** гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг;

**“ашигт малтмалын баялаг”** гэж геологийн зураглал, сэдэвчилсэн судалгаа, эрэл, хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн, эдийн засгийн ач холбогдол нь нарийвчлан үнэлэгдээгүй эрдсийн хуримтлалын хэсгийг;

## УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

**“ашигт малтмалын ордын нөөц”** гэж хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн нь нарийвчлан тогтоогдсон, үйлдвэрийн аргаар олборлох

боломжтой, эдийн засгийн үр ашигтай, баяжуулах технологи, олборлолтын уул техникийн нөхцөл нь тодорхойлогдсон ашигт малтмалын баялгийн хэсгийг;



## ӨМНӨХ ҮГ

**М**онгол Улс байгалийн асар их баялагтай. Өнөөгийн байдлаар ашигт малтмалын 50 гаруй төрлийн 3000 гаруй орд, илэрц судлагдаад байна. Ашигт малтмал, газрын тосны газрын 2020 оны 04 дүгээр сарын статистик мэдээгээр Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт нийт 2754 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдсоны 1674 нь ашиглалтынх үлдсэн 1080 нь хайгуулын тусгай зөвшөөрөл байна. Харин бичил уурхайн зориулалтаар 16 аймаг, нийслэлийн 272 нэгж талбарт 1.113.4 га газар олгосон байна<sup>1</sup>. Газрын тосны хувьд 25 талбайд 21 гэрээлэгч Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй<sup>2</sup> байгаа бол 130 гаран баяжуулах үйлдвэр, 5 боловсруулах үйлдвэр байна<sup>3</sup>.

Дээр дурьдсан 50 гаран төрлийн ашигт малтмал нь газрын хэвлийд янз бүрийн орон зайд, янз бүрийн хэлбэр хэмжээтэй байдаг төдийгүй тухайн газар нутгийн онцлог, ашигт малтмалын нөөцөөс шалтгаалан түүнийг олборлох технологи олон янз байдаг. Үүнтэй холбоотойгоор өөр өөр эрх зүйн орчин, мөчлөгүүд түүний үргэлжлэх хугацаа харилцан адилгүй байдаг ч зарчмын хувьд олборлохын

өмнө, олборлох үе, олборлосны дараах үе тэдгээрт иргэдийн оролцоо, ил тод нээлттэй байх нь зарчмын хувьд ижил байна.

Мөн ямар төрлийн ашигт малтмал байхаас үл хамааран тухайн хайгуул, олборлолтын үйл ажиллагаа нь (1) хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй, наанадаж одоогийн амьдрах орчныг хөндөж доройтуулахгүй, (2) экосистем, экологийн хамгийн бага нөлөөлөл үзүүлэхүйц, хэрэв мэдэгдэхүйц доройтол учруулж байгаа бол нөхөн төлөх, сэргээх бодлого, санхүүгийн нөөцтэй байхаас гадна (3) хүний эрх болон уламжлалт соёл, зан заншил, экологид хохирол учруулсан тохиолдолд нөхөн төлбөр төлж, эрхийг сэргээх хариуцлага хүлээх үүрэгтэй.

Монголын ард түмэн бид Үндсэн хуулиараа

- улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
- хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
- төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,

<sup>1</sup> <https://www.mrpam.gov.mn/public/pages/165/2020-03-stat-report-mon.pdf>

<sup>2</sup> <https://www.mrpam.gov.mn/article/49/>

<sup>3</sup> <https://www.mrpam.gov.mn/article/165/>

## УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

- хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
- эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхээ зарлан тунхагласан ард түмэн билээ.

Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамаалалтад байна” гэж 1992 онд баталгаажуулсан бол 2019 оны нэмэлт өөрчлөлтөөр “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж хуульчлаад байна.

Ийнхүү Монгол орны байгалийн баялаг ард түмний мэдлийнх учраас иргэн Та, олборлох салбарын үйл ажиллагааг ил тод нээлттэй, хариуцлагатай болгохын тулд Үндсэн хуулиар олгогдсон “баялгийн эзний хувьд мэдээлэл авах, хянах, нөлөөлөх, хариуцлага тооцох эрх”-тэй төдийгүй “эрүүл мэнд болон байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг”-ээ хэрэгжүүлэх маш чухал цаг үе болсон байна.

Манай улсын хувьд нүүдлийн мал аж ахуйтай зэрэгцэн уул уурхайн хайгуул, олборлолтын бизнесийн

үйл ажиллагаа явагддаг онцлог тул байгаль экологи доройтох, бэлчээрийн талбайн биомассын өгөөж багасч хомсдоход малчин өрхийн орлого, хүнсний аюулгүй байдал, гэр бүл түүний дотор эмэгтэйчүүд, охид, ахмад настанд хамгийн түрүүнд сөрөг нөлөөлөл мэдрэгддэг бөгөөд түүнийг даван туулах, дасан зохицоход ихээхэн бэрхшээл туулах, хүчин чармайлт гаргах болдог. Иймээс уул уурхайн нөлөөллийн бүсийн иргэд, малчид, хүний эрхийн хамгаалагчид олборлох салбарын талаар наад захын мэдлэг, ур чадвартай байх шаардлагатай.

Монгол Улсын Засгийн Газраас уул уурхай, ашигт малтмалын олборлолтыг тусгайлан хөхүүлэн дэмжиж байгаатай холбоотойгоор манай улсын аймаг, сум бүхэнд том, жижиг хэмжээ бүхий гадна болон дотоодын хөрөнгө оруулалттай олон төрлийн уурхайн олборлолтууд хийгдэж байна. Харамсалтай нь олборлолт хийж буй дийлэнх компаниудын хайгуул хийх, олборлолт явуулах процесс нь иргэдэд ил тод биш, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийн үнэлгээнүүдийг хийхдээ иргэдийг хангалттай түвшинд оролцуулж хийгээгүйгээс олон мянган малчин иргэд, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хохирч байна.

Тиймээс Монголын Эмэгтэйчүүдийн Сан нь 2016 оноос Тэтгэлэг олгох хөтөлбөрийн стратеги чиглэлдээ



“Эмэгтэйчүүдийн эрх ба байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт”-ийн асуудлыг шинээр оруулж, ажиллаж эхлээд байна. Энэ хугацаанд шороон ордын алтны олборлолт ихээр явагдаж буй Архангай, Булган, Дархан-Уул, Завхан, Багануур дүүрэгт шат дараатай төслүүдийг 3 жил хэрэгжүүлэх хугацаандаа орон нутгийн уугуул иргэд, малчдын бүлэг, эмэгтэйчүүдийн ТББ-уудыг чадавхжуулах, мэдлэгтэйгээр хяналт, мониторинг, нөлөөллийн ажил хийхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгохыг зорьж байгаа юм.

Баялгийн жинхэнэ эзэд болох энгийн иргэд та бүхэн жам ёсны эрх ашгаа, нутаг усныхаа эко систем, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ хамгаалж эвлэлдэн нэгдэж, хамтын хүчээр уул уурхайн салбарын үйл ажиллагаанд утга учиртайгаар оролцож чадаж гэмээ нь төрийн эрх баригчдын эрх мэдлээ хэтрүүлэн авилга, ашиг сонирхолын зөрчил дээр шийдвэр гаргахаас сэргийлж чадах билээ.

Энэ удаагийн гарын авлага нь уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа иргэд, тухайлаад эмэгтэйчүүд уул уурхайн салбарын онцлогийн талаар мэдээлэлтэй байж, үйл ажиллагааг нь тогтмол хянаж, зөрчил илэрсэн тохиолдолд хариуцлага тооцож ажиллахад тань шаардлагатай мэдлэг, ур чадвар өгөх болно гэдэгт итгэлтэй байна.

Иргэд, та бүхэнд ойлгож ашиглахад хялбар байх үүднээс алт олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мөрддөг эрх зүйн орчин, мөчлөг тус бүрт мөрддөг баримт бичгүүд тэдгээрт иргэдийн оролцох, мэдээлэл авах, төрийн байгууллагын ил тод нээлттэй байх үүрэг, талуудын хамтын ажиллагаа, зарим сайн туршлага, сургамж дээр тулгуурлан боловсруулж, арга зүйн хувьд ач холбогдолтой болгохыг зорилоо. Хэдийгээр зөвхөн ашигт малтмалын хайгуул, алт олборлолтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн асуудалд тулгуурласан ч ашигт малтмалын бусад төрөл, газрын тос, уран, хүнд үйлдвэрийн салбарт энэ гарын авлагыг адилтган хэрэглэх боломжтой юм.

Энэхүү гарын авлагыг боловсруулах, хэвлэн таны гарт хүрэх боломжийг олгосон “Эмэгтэйчүүдийн эрх ба байгаль орчны шударга ёс төсөл” түүнийг санхүүжүүлсэн GAGGA (Ногоон ба Жендэрийн нөлөөллийн төлөө дэлхийн альянс байгууллага), МОНЭС-т талархал илэрхийлье.

Гарын авлагын нэгдүгээр бүлэгт хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулах үйл явцад иргэдийн оролцоо, өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжууд, компанийн болон орон нутгийн засаг захиргааны эрх үүрэг; хоёрдугаар бүлэгт олборлолтын тусгай зөвшөөрөл олгох үйл явцад

## УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

орон нутгийн захиргаа, иргэдийн оролцоо тэдний эрх үүргүүд, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компани болон орон нутгийн засаг захиргаанаас олон нийтэд нээлтэй байх ёстой бичиг баримт, иргэдийн оролцоо; гуравдугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөөг төр болон бизнесийн хамгаалах, хүндлэх үүрэг, эмэгтэйчүүдийн эрх; дөрөвдүгээр бүлэгт уул уурхайн уул уурхайн сөрөг

нөлөөллөөс эрх ашгаа хамгаалж буй манлайлагчдын түүхээс оруулсан болно.

Энэхүү гарын авлагын талаар санал шүүмж, зөвлөгөө тайлбар хүлээн авахдаа баяртай байх болно. Мөн энэхүү гарын авлагад орсон агуулгаар сэдэвчилсэн сургалтууд зохион байгуулах боломжтойг хэлэхэд таатай байна.

---

### **Бидэнтэй холбогдох хаяг:**

Монголын эмэгтэйчүүдийн сан /МОНЭС/:

утас: 7011- 9991;

и-мэйл хаяг: [info@mones.org.mn](mailto:info@mones.org.mn)

Хил хязгааргүй алхам ТББ

утас: 70006061;

и-мэйл хаяг: [swb.ngo@gmail.com](mailto:swb.ngo@gmail.com)

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

# АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

- Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц
- Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг
- Хайгуул хийх мөчлөг дэх иргэдийн оролцоо
- Хайгуул хийх мөчлөг дэх талуудын хамтын ажиллагаа



## 1. ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

### 1.1. Хайгуулын тусгай зөвшөөрөл

Төрөөс ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход: (1) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ байх; (2) Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээд байх гэсэн үндсэн хоёр шаардлага тавьдаг хуулийн зохицуулалттай. 2006 оноос өмнө ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хүсэлт гаргасан хувь иргэнд олгодог байсан бол 2006 оноос эхлэн зөвхөн хуулийн этгээдэд өргөдөл гаргасан дарааллаар олгож байв. Харин 2015-2017 онд өргөдлөөр болон сонгон шалгаруулалтын холимог арга ашиглаж байсан бол 2017 оноос хойш зөвхөн сонгон шалгаруулалтаар олгох эрх зүйн зохицуулалт хэрэгжиж байна.

Нэг тусгай зөвшөөрлийг зөвхөн нэг хуулийн этгээдийн нэр дээр олгодог. Харин нэг хуулийн этгээдийн эзэмших тусгай зөвшөөрлийн тоонд хязгаарлалт байхгүй юм. Нэг тусгай зөвшөөрлөөр олгох хайгуулын талбайн хэмжээ 25 гектараас багагүй, 150 мянган гектараас ихгүй байх эрх зүйн зохицуулалттай. Нөөцөө тогтоосон бол тухайн ААНБ-д давуу эрхээр хайгуулын талбай дотор багтаан ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгодог.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад ямар ч тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглах хориотой.

**Ашигт малтмалын тойм судалгаа, эрлийн ажил гэдэг** нь ашигт малтмал байгаа эсэхийг тогтоох зорилгоор газрын хэвлийг хөндөхгүйгээр чулуулгийн сорьц, дээж авах, геологи, ашигт малтмалын анхдагч мэдээллийг ашиглах, агаарын зураг авах аргаар геологийн судалгаа хийхийг ойлгоно. Төр хайгуулын геологи судалгааны ажлыг бие даан хийхэд тэр бүр хангалттай хэмжээний зардал, хүн хүчний нөөц болон технологийн хувьд хязгаарлагдмал байдаг. Ийм учир хувийн хэвшил өөрийн хөрөнгөөр эрэл, хайгуулын судалгааны ажил хийж нөөц тогтоохыг эрх зүйн хувьд зөвшөөрдөг байна.


**Ашигт малтмал хайх гэдэг** нь эрлийн судалгааны ажлын үр дүнд илрүүлсэн эрдсийн хуримтлалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, түүний нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийх үйл ажиллагааг хэлнэ.

**Хайгуулын тусгай зөвшөөрөл** гэдэг нь дээрх үйл ажиллагааг явуулах эрхийг АМТХ-ын холбогдох шаардлага хангасан ААН-д олгосон баримт бичгийг хэлнэ.

Ашигт малтмалын тухай хуульд зааснаар Ашигт малтмалын ордыг дараах байдлаар ангилан авч үздэг.

Үүнд:

- a. стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд;
- b. түгээмэл тархацтай ашигт малтмалын орд;
- c. ердийн ашигт малтмалын орд гэж ангилна.



## 1.2. Ердийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион байгуулах, тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг АМГТГ зохион байгуулна.

1.АМГТГ хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох боломжтой сонгон шалгаруулалтын талбайг солбицлоор тодорхойлно

2.АМГТГ сонгон шалгаруулалтын талбайн солбицол тогтоосон материалаа тухайн амьгийн Засаг даргад санал авахаар хүргүүлнэ. Аймгийн Засаг дарга 45 хоногт багтаан саналаа ирүүлнэ

3.Аймгийн Засаг дарга ирүүлсэн материалтай танилцаж тухайн сум/ дүүргийн ИТХ-д уламжлан санал авна.

6.АМГТГ нь аймгийн Засаг даргын саналд үндэслэн шийдвэрээ гаргаж Засгийн газарт хүргүүлэн, сонгон шалгаруулалтын талбайн солбицолыг эцэслэн тогтоож зарлана.

5.Аймгийн ИТХ- нь сумын ИТХ-ын саналд үндэслэн шийдвэрээ гаргах бөгөөд Аймгийн Засаг дарга энэ хоёр шатны төлөөллийн байгууллагын саналд үндэслэн гаргасан шийдвэрээ АМГТГ-т хүргүүлнэ.

4.Сумын ИТХ тухайн сонгон шалгаруулалтын талбайг зөвшөөрөх эсэх асуудлаар ЗЕХ-ын дагуу сонсох ажиллагаа явуулж үр дүнг аймгийн ИТХ-д хүргүүлнэ.

7.Засгийн газрын баталсан солбицолд үндэслэн АМГТГ хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг ялган, үндэсний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр зарлана. Ингэхдээ сонгон шалгаруулалт явуулахаас 30 хоногийн өмнө зарлан мэдээлнэ.

8.АМГТГ дуудлага худалдаанд оролцогчдын материалыг хүлээн авч санал ирүүлсэн дарааллаар бүртгэж авна. Сонгон шалгаруулалтын комисс байгуулна.

9.АМГТГ санал ирүүлсэн ААН-ийн материалд Техникийн болон үнийн саналд үнэлгээ өгч хамгийн өндөр үнэлгээ авсан ААН-ийг шалгарсанд тооцон мэдэгдэж Тусгай зөвшөөрлийн төлбөр төлснөөр Хайгуулын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгоно.

төрийн захиргаа, ЗГ оролцоо

орон нутгийн захиргааны оролцоо

иргэдийн оролцоо

### 1.3. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг:

#### А. Дараах нийтлэг ЭРХ эдэлнэ:

1. Хайгуулын талбайн хилийн дотор ашигт малтмал эрэх, хайх;
2. Нэг хуулийн этгээд хэдэн ч хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж болно.
3. Хайгуулын талбайн аль ч хэсэгт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг давуу эрхийн дагуу авах;
4. Хайгуулын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, талбайг эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, хяналтын дор бүхэлд нь эсхүл хэсэгчлэн буцаан өгөх;
5. Цацраг идэвхт /уран/ ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг 3 жилийн хугацаагаар 3 удаа нийт 9 жил хүртэл сунгуулах;
6. Хайгуулын ажил явуулах зорилгоор хайгуулын талбайд нэвтрэн орох, шаардлагатай түр барилга байгууламж барих;
7. Хайгуулын талбайд нэвтрэн орохын тулд хайгуулын талбайн гаднах газар нутгаар дамжин өнгөрөхдөө бусдын өмчлөл, эзэмшилд байгаа газарт түүний өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрсний дагуу нэвтрэх, дайран өнгөрөх.

#### Б. Дараах нийтлэг ҮҮРЭГ хүлээнэ.

1. Дараах бичиг баримтыг хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа газар дээр байлгаж олон нийт танилцах боломж олгоно.

1. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хуулбар, ар талаас сунгалтыг харах;
2. Жил бүрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан;
3. АМГТГ болон МХГ-аар хянуулсан жил бүрийн хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан
4. Орон нутгийн Хамтын ажиллагааны гэрээ, дүгнэлт тайлан. жил бүрээр
5. Газар ашиглах гэрээ, төлбөр тушаасан баримт, тайлан жил бүрээр
6. Ус ашиглах гэрээ, холбогдох газрын дүгнэлт, төлбөр тушаасан баримт, тайлан жил бүрээр

#### В. Байгаль орчныг хамгаалах талаар хүлээх ЗААВАЛ БИЕЛҮҮЛЭХ үүрэг:

1. Тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор аймгийн БОАЖГ болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө / БОХ / боловсруулна.

## УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

2. БОХ төлөвлөгөөнд: Хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээ түүний зардлыг тусгах;
3. БОХ төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргаар батлуулна.
4. Батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/- буюу байгаль хамгаалах төлөвлөгөөний хувийг хайгуулын талбай байршиж байгаа сум, дүүргийн байгаль орчны байцаагчид хүргүүлж хяналт тавих, олон нийт танилцах бололцоог олгоно.
5. Хайгуулын ажлын явцад үүссэн байгаль орчны сөрөг нөлөөллийг тухай бүр бүртгэн БОМТ-ний жилийн тайланд тусгах бөгөөд уг тайланг байгаль орчны байцаагч болон тухайн сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж хяналт тавих, олон нийт танилцах бололцоог олгоно.
6. БОМТ-ний тайланд: байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хайгуулын ажилд ашигласан шинэ техник, технологи, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх чиглэлээр төлөвлөгөөнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай саналыг тусгаж уг өөрчлөлтийг сум, дүүргийн Засаг даргаар батлуулна. Засаг дарга БОМТ-г хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор батлана.
7. Байгаль орчны болон Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтанд хайгуулын талбайд нэвтрэн орох, газар дээр нь шалгалт хийх бололцоо олгож, хяналт тавих, олон нийт танилцах бололцоог олгоно.
8. Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүр шилжүүлэн байршуулах.
9. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь БОМТ-д тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга тусгай дансанд байршуулсан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг жил бүр гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулан авч зарцуулна.
10. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь БОМТ-д тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн эсэхийг



нутгийн захиргаанаас томилогдсон комисс хүлээн авсан бол Засаг дарга тусгай дансан дахь мөнгөн хөрөнгийг буцаан олгоно.

11. Ашигт малтмал эрэх, хайх явцад олж илрүүлсэн соёлын өвийн бүрэн бүтэн байдлыг хангаж, соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэн тухайн өвийг холбогдох байгууллагад шилжүүлэх үүрэг хүлээнэ.
12. Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авах үүрэгтэй. Энэ зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.

#### **Г. Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх БИЕЛҮҮЛЭХ үүрэг:**

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын үйл ажиллагааны явцад тусгай зөвшөөрлийн талбай дахь
  - худаг,
  - өвөлжөө, хаваржаа
  - хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж
  - түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол
  - хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай

тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг бүрэн хариуцна.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон тухайн сум, дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байж түүнд санхүүжилт гарган ажиллах үүрэгтэй.

#### **Д. Нутгийн захиргааны байгууллагатай харьцах БИЕЛҮҮЛЭХ үүрэг**

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь жил бүр

- байгаль орчныг хамгаалах,
- уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх,
- ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээ байгуулах асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно. Энэхүү гэрээ нь нийтийн эрх зүйн харилцааг үүсгэж байгаа тул Захиргааны ерөнхий хуулийн дагуу эрх ашиг нь шууд хөндөгдөх нөлөөллийн бүсийн иргэдийн тайлбар, санал авах сонсох ажиллагааг заавал зохион байгуулна.

### **Е. Мэдээ тайлан гаргах, сурталчлан танилцуулах БИЕЛҮҮЛЭХ үүрэг**

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах мэдээ, тайлан, төлөвлөгөөг үнэн зөв гаргаж иргэд, нутгийн хамт олонд танилцуулж, АМГТГ болон МХГ-т хүргүүлнэ:

1. Жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны дотор - а/. уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон б/. тухайн сум, дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангасан талаар тайланг АМГТГ болон МХГ-т хүргүүлнэ:
2. 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор - Хайгуулын ажлын жилийн тайланг АМГТГ-т хүргэнэ. Уг тайланд тухайн талбайд хийгдсэн тойм судалгаа, геофизик, геохими, өрөмдлөг болон бусад бүх төрлийн ажлын тоо хэмжээ, өртөг, зардал, ажиллах хүчинтэй холбогдсон мэдээ, түүнчлэн хайгуулын ажлын үр дүн, тухайн талбайд хийгдсэн ажлын зургийг хавсаргах бөгөөд түүнийг улсын геодезийн зураглалын тулгуур сүлжээтэй холбосон байна.
3. 04 сарын 01 ний дотор - Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг олон нийтэд нээлттэй мэдээлнэ.
4. 04 дүгээр сарын 15-ны дотор - Хайгуулын ажлын төлөвлөгөөг хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш 30 хоногийн, дараагийн жилүүдэд тухайн оны төлөвлөгөөг АМГТГ-аар батлуулна.
5. Жил бүр - Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын 50 хувийг сум, дүүргийн засаг даргын нээсэн тусгай дансанд байршуулах, нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгөөд буцаан авсан мэдээллээ нэгдүгээр улиралд багтаан мэдээлэх. Сумын Засаг дарга хэдэн ААНБ барьцаа хөрөнгө төвлөрүүлсэн, хэд нь буцаан авсан, хэдэн компаний барьцаа хөрөнгөөр хэрхэн нөхөн сэргээлт хийлгэж дутсан санхүүжилтийг хэрхэн татан авч, хаана хэдэн га-д нөхөн сэргээлт хийлгэсэн тайлангаа 12 сарын ИТХ-ын жилийн эцсийн хуралдаанд танилцуулж олон нийтэд нээлттэй мэдээлнэ.
6. ТЭЗҮ: Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн тайланг ашигт малтмал эрэх, хайх үйл ажиллагааны журам, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалд нийцүүлэн боловсруулж, шинжээчийн дүгнэлт гаргуулан АМГТГ-т хүлээлгэн өгнө.

7. АМГТГ нь ТЭЗҮ-д Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс мэргэшсэн мэргэжилтнийг шинжээчээр 30 хоногт багтаан томилж, 90 хоногт багтаан хэлэлцэж дүгнэлт гаргуулсны үндсэн дээр уг нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд

бүртгэх, хүлээн авах, тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийг анхдагч материалын хамт мэдээллийн санд бүртгэх тухай шийдвэр гаргана.

8. АМГТГ тусгай зөвшөөрөл эзэмшигчээс дутуу ирүүлсэн мэдээ, тайланг шаардах эрхтэй.

#### 1.4. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бичиг баримтууд

	<i>Компани дээр байх ёстой, нийтэд нээлттэй баримт бичиг</i>	<i>Ямар мэдээлэл авч болох</i>
1	<b>АМТХ.</b> 17-р зүйлийн 17.4. Лицензийн нийт талбайн хэмжээ 25 га-аас их, 150 га-аас их биш байгаа эсэх,	Талбайн хэмжээг харах
2	<b>АМТХ.</b> 34 дүгээр зүйлийн 34.1.Хайгуулын лиценз авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан лицензийн төлбөрөө төлсөн баримт	Төлбөрийн баримтыг үзэх
3	<b>АМТХ.</b> 19 дүгээр зүйлийн <b>19.8.</b> Хайгуулын лицензийн хугацаа: хэд дэх жил..... хэд дэх..... сунгалттай байгаа	Лицензийн гэрчилгээ, хуулбараас үзэх
4	<b>АМТХ.</b> 35 дугаар зүйлийн 35.3.1.Хайгуулын тусгай зөвшөөрлийн хуулбар	Хуулбар
5	<b>АМТХ.</b> 35 дугаар зүйлийн 35.2.2.Засаг даргаар батлуулсан жил бүрийн БО-ны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлтийн тайлан	Тайлангийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж төлөвлөгөөтэй тулгаж харах
6	<b>АМТХ.</b> 38 дугаар зүйлийн 38.1.8.БО-ыг нөхөн сэргээхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сумын Засаг даргын тусгай санд байршуулсан баримт, нөхөн сэргээлт хийж буцааж дэнчинг авсан эсэх	Жил бүрийн баримтыг үзэх
7	<b>АМТХ.</b> 41 дүгээр зүйлийн 41.1. Хайгуулын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг хэрхэн шийдвэрлэсэн	Баримтуудыг үзэх, асуулт тавьж хариулт авах, кейс дээр жишээ авч хариулт авах

## УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

8	<b>АМТХ.</b> 42 дугаар зүйлийн 42.1. Нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажилласан байдал	Гэрээг үзэх. Иргэд, ИНБ-ын оролцоог хангасан байдал
9	<b>АМТХ.</b> 48 дугаар зүйлийн 48.10. Тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, биет болон биет бус хандивын хэмжээний тайлан, түүнийг олон нийтэд мэдээлсэн эсэх, хэрхэн яаж	Тайлагнасан эсэх, тайлагнасан хэлбэр
10	АМТХ. 35 дугаар зүйлийн 35.3.7. Сумын Засаг даргаас газар, ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулсан эсэх	Газар ус ашиглах гэрээ хийгдсэн огноо. Усны төлбөр тогтоосон дүгнэлтийн хамт
11	АМТХ. Хайгуулын ажлын явцад нөхөн сэргээлт хийсэн эсэх, түүнийг хүлээж авсан дүгнэлт, түүнд иргэдийн төлөөллийг оролцуулсан эсэх	Нөхөн сэргээт хүлээн авсан комиссын акт, нутгийн иргэдээс хэн хэн байна
12	АМТХ. АМГТГ-Аймгийн Засаг даргад –Сумын ИТХ-д- Аймгийн ИТХ-д- Аймгийн ЗД-д- АМГТГ-т санал хүсэлт хэрхэн явагдсан, 45 хоногийн дотор хүргүүлсэн албан хариу өгсөн байдал	ЗДТГ-ын ирсэн явсан бичгийн хөтөлгөө болон хурлын тэмдэглэлээс харах
13	<b>АМТХ.</b> 38 дугаар зүйлийн 38.1.6. БОХ талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, хайгуулын ажилд ашигласан шинэ техник, технологи, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулсан эсэх	Төлөвлөгөөг үзэх түүнийг Засаг дарга баталсан эсэх, хэрэгжилтийг газар дээр нь үзэх
14	<b>БОНБҮТХ.</b> 9 дүгээр зүйлийн 9.12. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа байдал	Хяналт хийсэн тэмдэглэл, түүний мөрөөр авсан арга хэмжээг бичиг баримтаас үзэх

### 1.5. Хайгуулын шатанд олон нийт, иргэний оролцоо

МУ-ын Үндсэн хуулийн 6-р зүйлийн 6.2 дахь хэсэгт: “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.” гэж 2019 оны 11 сарын нэмэлт, өөрлөлт орууллаа.

Энэ нь иргэд нэг хоёроор болон багаараа, нөхөрлөл, хоршоогоор болон ТББ-ын оролцоотой эрхээ хэрэгжүүлэхэд онцгой ач холбогдолтой заалт боллоо. Иргэдийн оролцоо гэдэг бол зөвхөн мэдээлэл сонсох, танилцуулга хийсэн танхимын уулзалтад оролцохоор хязгаарлагдах ёсгүй юм.

Тэгвэл юуг оролцоо гэж үзэх вэ? Иргэд, олон нийтийн оролцоо гэдэг нь эрхээ хамгаалах, өөрийн болон гэр бүл, нийгэм, нутгийнхаа хөгжлийг тодорхойлоход урьдчилсан мэдээллээр хангагдах, санал бодлоо хараат бусаар илэрхийлэх, бодлогод тусгуулах, хэрэгжилтэд хяналт мониторинг хийх, хариуцлага шаардах, гомдол гаргаж шийдвэрлүүлэх тасралтгүй цикл бүхий үйл явц юм.

Тэгвэл оролцооны эрхийн үйл явц гэдэг нь дараах бүх элементүүд хангагдахыг хэлнэ.

	<i>Оролцох эрхийн бүрэлдэхүүн</i>	<i>Бүрэлдэхүүн тус бүрийн хангагдах гэдэг нь</i>
I	Үнэн зөв мэдээлэл авах, бодит, цаг үеэ олсон, хэрэгтэй мэдээллээр хангагдах эрх  /Энд мэдээллийн чанарын асуудал маш чухал/	<ul style="list-style-type: none"> <li>• Цаг хугацааны хувьд хоцрогдоогүй мэдээлэл байх</li> <li>• Үнэн бодит, баталгаатай мэдээлэл байх;</li> <li>• Энгийн, ойлгомжтой үг хэллэг, бичвэрээр бичигдсэн байх</li> <li>• Хаанаас тодруулга тайлбар авах эх сурвалж, харилцах утас мэдээлэл өгөх хүний нэрийг дурьдсан байх;</li> <li>• Харьцуулах, дүгнэх боломжтой мэдээлэл байх;</li> <li>• Тусгай хэрэгцээ бүхий хүмүүс тухайлбал, хараа, сонсголын бэрхшээлтэй иргэд, нярай хүүхэдтэй болон гэрээр байгаа эмэгтэйчүүд, өрх толгойлсон эрэгтэй эмэгтэй хүмүүс, ахмадууд мэдээлэл авах боломжийг зохистой хэлбэрээр хангах;</li> </ul>
II	Олж авсан мэдээлэл дээрээ зөвлөлдөх оролцоо, Үзэл бодлоо илэрхийлэх, санал хэлэх, шийдвэрт саналаа тусгах	<ul style="list-style-type: none"> <li>• Иргэд олж авсан мэдээлэлдээ хувийн зүгээс дүгнэлт хийх, санал боловсруулах улмаар хот айл хоорондоо зөвлөлдөх, холбогдох хүмүүс, байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах хангалттай хугацааны дараа санал авах ажлыг эхлэнэ.</li> <li>• Зөвлөлдөх нь шийдвэр гаргагчид болон олон нийтийн хооронд харилцан мэдээлэл,</li> </ul>

## УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

		<p>байр суурь, санал солилцох, мэтгэлцэх замаар сайн хувилбар гаргах; боломжтой болгож хоорондын түншлэлийн суурь болдог</p> <ul style="list-style-type: none"> <li>Иргэд, нутгийн хамт олон хэрэв өөрийн үзэл бодол, байр сууриа шийдвэр гаргахад нөлөөтэй тусгаж чадахгүйд хүрвэл үзэл бодлоо хамгаалах, яагаад шийдвэрт өөрийн санал тусгагдах боломжгүй, эсвэл өөр утгаар хэрхэн томъёологдож байгаа талаар тайлбар авах боломжтой байх;</li> <li>Тухайн хуралд ирээгүй, ирэх боломжгүй охид, эмэгтэйчүүд, ахмадууд, ганц биеэр малаа маллаж байгаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн саналыг хэрхэн авах, түүнийг бусдад нээлттэй мэдээлэх боломж орчныг бүрдүүлсэн байх, ялангуяа нөлөөллийн бүсийн иргэдийн саналыг заавал авч аль болох тусгах;</li> </ul>
III	Иргэд өөрийн оролцож гаргасан шийдвэрийн хэрэгжилтэд бүтээлч идэвхитэй оролцох, хамтран ажиллах оролцоо	<ul style="list-style-type: none"> <li>Хамтран ажиллах бол оролцооны хамгийн идэвхитэй хэлбэр юм. Тухайлбал, Хамтын ажиллагааны гэрээний хороонд орж ажиллах, гэрээ байгуулах ажлын хэсэгт ажиллах, нөхөн сэргээлт хүлээж авах комисст орж ажиллах;</li> <li>Олон нийтэд мэдээлэл өгөх танилцуулга хийх үүргээ хэрэгжүүлэхийг ААН болон нутгийн захиргаанаас шаардах ажлыг манлайлах, зохион байгуулах бэлтгэл хангахад оролцох гэх мэтээр идэвхитэй оролцоог дэмжих;</li> <li>Гэхдээ энэ идэвхитэй оролцоо нь нийтийн эрх ашгийн төлөө, нийтлэг том зорилго, эв санааны нэгдлийн хүрээнд байх;</li> </ul>
IV	Хяналт мониторинг хийх	<ul style="list-style-type: none"> <li>Иргэд, нутгийн хамт олон анхны шийдвэрийн төсөл боловсруулах шатанд гаргаж байсан үзэл бодол, байр суурь, санал хэрхэн хэрэгжиж байгаад тогтмол хяналт мониторинг хийхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл нь ил тод нээлттэй, олдоцтой, олж авахад амар хялбар байх,</li> <li>Шаардлагатай мэдээллийг шуурхай гаргаж өгөх, анхнаасаа ямар мэдээллийг хаана, ямар хугацаанд хэрхэн нээлттэй болгохыг тогтсон журам гаргасан байх</li> <li>Хяналт мониторингийн дүгнэлтийг талууд хэлэлцдэг, хүлээн зөвшөөрдөг байх, түүний мөрөөр арга хэмжээ авч хэрхэн нөхцөл байдал дээрдүүлэх, ахиц дэвшил гаргах талаар харилцан мэдээлэл солилцох боломжийг хангаж өгсөн байх;</li> </ul>
V	Гомдол гаргах замаар эрхээ сэргээлгэх эрх	<ul style="list-style-type: none"> <li>Оролцооны эрх болон гаргасан шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй эсвэл гажуудуулсанаас иргэд, нутгийн хамт олны, нийтийн эрх ашиг зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй болсон бол гомдол гаргах түүнийг шуурхай шийдвэрлэх, арга хэмжээ авах хялбар механизм бий болгосон байх;</li> </ul>

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хайгуул хийх үе шатанд иргэд, нутгийн хамт олны оролцооны эрх гэдэгт дээрх бүрэлдэхүүнүүд цогцоор хангагдсан байх шаардлагатай. Иймд:

- Засгийн газрын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын солбицол тогтоох асуудлаарх албан бичиг хэзээ сумын ИТХ-д ирсэн, 45 хоног дуусахад хэд хоног үлдсэн талаар мэдээлэл авч түүнийг нээлттэй, ил тод болгохыг ИТХ-д шууд болон төлөөлөгчөөрөө дамжуулан хүсэлт гаргах. Ер нь сумын ИТХ-ыг хайгуулын болон ашиглалтын сонгон шалгаруулалтын солбицол тогтоох асуудлаар АМГТГ /аймгийн Засаг даргаас санал авах албан тоотыг ирсэн өдөр нь ил тод нээлттэй зарлаж байх журам гаргуулсан байх.
- Сонгон шалгаруулалт явуулах солбицол нь танай баг, сумын ямар нэртэй газар дээр хэний өвөлжөө хаваржааны ойр тогтоогдож байна, тэгш өнцөгт хэлбэртэй байгаа эсэхийг лавлаж асуугаарай, өөрсдөө тогтоож ч болох юм.
- Сумын ИТХ, ЗДТГ-аас Захиргааны ерөнхий хуулийн 27-р зүйлийн дагуу ямар ч асуудлаар зохион байгуулах сонсох ажиллагаа бүрт заавал идэвхитэй оролцох хэрэгтэй

- Хэрэв ИТХ уулзалт, хэлэлцүүлэг, сонсох ажиллагааг олон нийтэд нээлттэй зарлаагүй, эсвэл сонсох ажиллагаа явуулахгүйгээр зөвшөөрсөн эсвэл татгалзсан санал хүргүүлсэн бол түүнийг нээлттэй болгох, үндэслэл тайлбар шаардах хэрэгтэй.
- Нэгэнт хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон бол ААНБ-ын сонгон шалгаруулалтын тендэрт ялсан үнийн дүн, техникийн шалгуур үзүүлэлт бүрийн үнэлгээг төдийгүй өрсөлдсөн ААНБ-ын нэрсийг АМГТГ-аас авч нээлттэй болгохыг сум, дүүргийн засаг дарга, АМГТГ-аас шаардах хэрэгтэй.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болох тухай АМТХ-ын 42.2 дахь заалтыг ашиглах боломжтой.
- Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших эрхийн гэрчилгээ гарснаас хойш 2 сарын дараагаас дээр дурьдсан үүргүүдийн хэрэгжилт, холбогдох бичиг баримтуудыг авч үзэх, танилцах, олон нийтэд танилцуулахыг баг, сумын Засаг даргаасаа шаардаарай.

### 1.6. Хайгуулын шатанд талуудын хамтын ажиллагаа

Олборлох салбарын хувьд оролцогч “талууд” гэдэгт (1) төрийн байгууллага; (2) тусгай зөвшөөрөл эзэмшигч түүний туслан гүйцэтгэгчид, зарим томоохон ханган нийлүүлэгчид; (3) нутгийн хүн ам, түүний дотор нөлөөллийн бүсийн малчид, иргэд болон нийтийн эрх ашгийн төлөө зорилго, үйл ажиллагааны чиглэл бүхий иргэдийн бүлэг, ТББ-ыг авч үздэг нийтлэг жишиг тогтоод байна.

Олборлох салбарт оролцогч талуудын идэвхтэй, бүтээлч оролцоог зөвхөн дүрэм журмыг сахиулахад /байгаль орчин, ашигт малтмалын тухай хууль, эсвэл орон нутгийн эрх мэдэлтнүүдээс тавих шаардлага эсвэл эрх ашиг нь хөндөгдсөн иргэдийн шаардлага г.м/ чиглэсэн шаардлага гэдгээр хязгаарлан ойлгож, хүлээн зөвшөөрч болохгүй.

Уул уурхайн аливаа төслийг амжилттай хэрэгжихэд, төслөөс нутгийн иргэд, орон нутаг тогтвортой бөгөөд шударга үр өгөөж хүртэхэд талуудын итгэлцэлд суурилсан харилцаа, зөв ойлголцлыг анхнаас нь бий болгож чадвал цаашид тэгш эрхтэй хамтын ажиллагаа төлөвших ач холбогдолтой юм.

Иймд нутгийн иргэд, ТББ-ууд дараах албан ёсны боломжуудыг ашиглаарай.

1. МУ-ын Засгийн Газрын 2012 оны 222-р тогтоолын дагуу сум /дүүрэг бүрт Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах дэд зөвлөлийг засаг даргын орлогч даргаар ахлуулан байгуулсан байх учиртай. Энэ зөвлөлд иргэд, ИНБ-ын төлөөлөл орж ажиллах хүсэлтээ гаргаж оролцоорой
2. АМТХ-ын 42-р зүйлийн дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч бүр нутгийн захиргааны байгууллагатай (а) байгаль орчныг хамгаалах; (б) уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх; (в) ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллах үүрэгтэй. Энэ хамтын ажиллагааны гэрээнд хяналт тавих Гэрээний хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах бөгөөд талуудын тэнцүү тооны төлөөлөлтэй байхыг заасан тул иргэд ИНБ-ын төлөөлөл орж ажиллах хүсэлтээ гаргаж оролцоорой. Энэ нь нутгийн захиргаа хэдэн компанитай гэрээ байгуулна түүний тоогоор тус хороо байгуулагдах тул иргэд, малчид, ИНБ-ын төлөөллийг 3 хүнээр хязгаарлахгүй гэсэн үг. өөрөөр хэлбэл 5 компанитай байгуулах гэрээнд 5 хороо байгуулагдах тул иргэд 15 малчид, иргэдийг сонгоно гэсэн үг.



3. Олборлох салбарт байгуулах гэрээ нь Захиргааны ерөнхий хууль 2017 онд хэрэгжиж эхэлснээр захиргааны гэрээ гэж тооцогдох болсон. Иймд эрх ашиг нь хөндөгдөх иргэдийн санал авах сонсох ажиллагааг заавал зохион байгуулахыг хуульчилсан. Харин сонсох ажиллагаа явуулахгүйгээр гэрээ байгуулсан тохиолдолд тухайн гэрээ ил хууль бус гэрээ болгож өгөх захиргааны шүүхэд хандах шаардлагатай.
4. Жил бүрийн 11 сард багтаан Багийн ИНХ-ын хуралдаан эсвэл багийн өдөрлөгөөр хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хайгуулын ажлын төлөвлөгөө, Байгаль хамгаалах төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангуудын талаар ААНБ болон


сум, дүүргийн БО ны улсын байцаагч, багийн болон сумын Засаг даргаар мэдээлэл хийлгэж хэлэлцэж байгаарай.

5. АМТХ-ын 48-р зүйлийн 48.10 дахь заалтын дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, нутгийн захиргаатай байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, хандив дэмжлэг, нөхөн сэргээлт хийсэн талбай түүний зардал, нөхөн олговор олгосон зардал төдийгүй орон нутгаас худалдан авалт хийсэн эсэх, ажиллах хүчин авсан эсэх зэрэг олон төрлийн дэлгэрэнгүй мэдээллийг танай баг, сум, дүүргийн иргэдэд гэлтгүй үндэсний хэмжээнд 1 дүгээр улиралд багтаан тайлагнах үүрэгтэй.



## УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

АШИГТ МАЛТМАЛЫН ХҮЧИН ТӨГӨЛДӨР ТУСГАЙ ЗЭВШӨӨРЛИЙН ТОО, 2016-2020



АМГТГ-ЫН УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН НИЙТ ОРЛОГО, тэрбум төгрөгөөр, 2016-2020



## ХОЁРДУГААР БҮЛЭГ

# АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төрөл, олгох үйл явц
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг
- Ашиглалтын мөчлөг дэх иргэдийн оролцоо
- Ашиглалтын мөчлөг дэх талуудын хамтын ажиллагаа



## 2. АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

### 2.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргах эрхтэй. Өргөдөлд уурхайн талбайн булангийн цэгийг төрийн захиргааны байгууллагаас баталсан нэг загварын газрын зураг дээр тэмдэглэж, солбицлуудыг градус, минут, секундээр тодорхойлж хавсаргана.

#### А. Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох аргачлал түүний төрөл:

- I. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч давуу эрхийн дагуу **өргөдлөөр ашиглалтын** тусгай зөвшөөрөл олгоно. (Хугацаа 30 жил + 20 жил +20 жил нийт 70 жил) Гэхдээ хайгуулын шатандаа байгаль орчны үүргээ хангалттай хэрэгжүүлж байсныг жилий бүрийн БОМТ-өөр баталгаажсан байх шаардлагатай.
- II. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөц нь тогтоогдсон талбайд **сонгон шалгаруулалтын журмаар** тусгай зөвшөөрөл олгоно. (Хугацаа 30 жил + 20 жил +20 жил нийт 70 жил)
- III. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч гуравдагч этгээдэд үүсмэл ордыг ашиглуулах тохиолдолд гэрээ

байгуулж, үүсмэл ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хэлэлцэн гаргасан дүгнэлт, шийдвэрийг үндэслэн АМГТГ-аас **үүсмэл орд ашиглах** тусгай зөвшөөрөл олгоно. (Хугацаа 3 жил)

#### Б. Ашиглалтын лицензийн төлбөрийн хэмжээ түүнийг төлөх:

- Ашиглалтын лицензийн төлбөр нь тухайн уурхайн талбайн гектар тутамд 21750 төгрөг байх бөгөөд харин шохойн чулуу, нүүрс, дотоодын үйлдвэрлэлийн зориулалттай ашигт малтмалын хувьд гектар тутамд 7250 төгрөг байна.
- Тусгай зөвшөөрлийн төлбөрийг жил бүр төлөх бөгөөд анхны жил ашиглалтын гэрчилгээ гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор төлнө. Төлөөгүй хоног тутамд 0,3 хувийн алданги тооцох бөгөөд мэдэгдсэн хугацаа дуусахад лицензийг цуцлана.

#### В. Ашиглалтын тусгай зөвшөөрөл авах хуулийн этгээдэд тавигдах шаардлага:

- МУ-д-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн дагуу байгуулагдсан ААН байх

- Дүрмийн зорилго, чиглэлийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг байх
- МУ-д татвар төлөгч байх
- Нэг тусгай зөвшөөрлийг нэг хуулийн этгээдэд олгоно.
- Лиценз эзэмших хүсэлт гаргах хуулийн этгээд өөрийн эцсийн эзэмшигч хувь хүний талаарх мэдээллийг татварын албанд бүртгүүлсэн байна.
- Өөрийн болон эцсийн эзэмшигчийн хувьцаа гадаад, дотоодын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагддаг бол лиценз эзэмшигч өөрийн эцсийн эзэмшигчийн өөрчлөлтийн тухай мэдээллийг тухайн жилийн 07 дугаар сарын 20-ны өдөрт багтаан, жилийн эцсийн мэдээллийг дараагийн татварын жилийн 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харьяалах татварын албанд бүртгүүлсэн байна.

#### **Г. Ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгох талбайд тавигдах шаардлага:**

1. Тал бүр тийш 500 метрээс багагүй урттай, уртраг, өргөргийн дагуух чиглэлтэй давхацсан шулуун шугамаар хүрээлэгдсэн тэгш олон өнцөгт хэлбэртэй;
2. Сум, аймгийн тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр

- нэгэнт олгогдсон талбайтай давхцаагүй;
3. Давс болон түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын тухайд талбайн хэмжээ нь тал бүр тийш 100 метрээс багагүй урттай.
  4. Давхцал гаргахгүйн тулд уурхайн талбайн дараахь газар нутаг, талбайтай хиллэж байгаа хэсэг нь шулуун шугам биш байж болно:

#### **Д. Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон талбай:**

1. Улсын хилийн зурвас газар,
2. Отор, бэлчээр, хадлан зэрэг нөөцөд авсан талбай;
3. Тусгай хэрэгцээний газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газар;
4. Уурхайн талбайд хамруулах боломжгүй гэж үзсэн нуур, цөөрөм зэрэг байгалийн тогтоц.
5. Голын эх түүний ай сав газар, голоос хоёр тийш 150 м зайд
6. Ойн сан бүхий газар ойгоос 150 м зайд
7. Соёлын өв бүхий газар
8. Археологи, палентологийн илэрц бүхий газар

#### **Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох аргачлал түүний төрөл:**

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл авахын өмнө компани дараах үе шаттай баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Өргөдлөөр тусгай зөвшөөрөл авахад дараах алхмуудыг, сонгон шалгаруулалт болон үүсмэл орд ашиглах лиценз авах бол 3-аас хойших алхмыг мөрдөнө.

**2.2.ХУВИЙН ХӨРӨНГӨӨР НӨӨЦ ТОГТООСОН ТАЛБАЙД АШИГЛАЛТЫН ЛИЦЕНЗИЙГ ӨРГӨДӨЛ ХҮЛЭЭН АВАХ ЖУРМААР ОЛГОХ ДАРААЛАЛ:**

**1.** АМГТГ-т өргөдөл гаргана.

**2.** Сум дүүргийн ЗД-аас хайгуулын шатандаа БО үүргээ хэрхэн хэрэгжүүлж байсан тодорхойлолт авна.

**3.** Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэнэ.

**4.** БИНХ-аар БОННУ-ний тайланг хэлэлцүүлнэ.

**5.** БОННУ-ний тайланд Багийн ИНХ-аас гарсан саналыг тусган БОАЖЯ-ны эрдмийн зөвлөлийн хурлаар батлуулна.

**6.** АМГТГ-т холбогдох материалыг хүргүүлж Ашиглалтын тусгай зөвшөөрлийг авна. Үүнд батлагдсан БОННУ заавал багтана.

**7.** Ашиглалтын лиценз олгосон талаар АМГТГ сумын ЗД-д мэдэгдэж өдөр тутмын сонинд зарлана.

**8.** Хамтын ажиллагааны гэрээг сумын захиргаатай байгуулна. Стратегийн орд бол аймгийн ЗД-тай байгуулна.

**9.** Хамтын ажиллагааны гэрээний төслөөр ЗЕХ-ын дагуу сонсох ажиллагаа явуулна. Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг ЗД иргэдэд тайлагнана.

**10.** БОМТ/ОХШХ-ийг жил бүр боловсруулж хэрэгжүүлнэ. БОННУ-г 5 жил тутам нэмэлт тодотгол хийнэ. 2 жил тутам Байгаль орчны аудит хийлгэнэ.

**11.** Эдгээр баримт бичгийг сумын ЗД батлана, хяналт тавина.

**12.** Ашиглалтын лиценз эзэмшигчийн Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө байршуулсан талаар БОЯ сумын ЗД-д мэдэгдэнэ.

**13.** Иргэдэд жил бүр ил тод нээлттэй тайлан тавьж санал авна.

■ яам, агентлагийн оролцоо

■ орон нутгийн захиргааны оролцоо

■ иргэдийн оролцоо

**ҮҮСМЭЛ ОРДОД АШИГЛАЛТЫН ЛИЦЕНЗИЙГ ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР ОЛГОХ ДАРААЛАЛ:****1-р алхам.****Үүсмэл орд ашиглах гэрээнд:**

- орд ашиглах, үйлдвэр байгуулахтай холбоотой дэд бүтэц
- газар, ус ашиглах, лицензийн г м бусад төлбөр, хураамж
- эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй ажилагаа
- БО-ыг хамгаалах, нөхөн сэргээх, хаалтын үүргийг тусгана.
- ТЭЗҮ батлуулсан байна.
- Нөөцийг эрдэс баялгийн зөвлөлөөр баталсан байна.

**2-р алхам.**

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч үүсмэл орд ашиглах тухай гэрээ байгуулснаас хойш 14 хоногийн дотор АМГТГ-т мэдэгдэнэ.

**3-р алхам**

- Үүсмэл орд ашиглах өргөдлөө АМГТГ-т гаргана. Өргөдөлд:
- Хуулийн этгээдийн нэр, утас, хаяг, шийдвэр гаргах эрх бүхий албан тушалан, АХЖЭ-ний дэлгэрэнгүй мэдээлэл

- Гуравдагч этгээдтэй гэрээ байгуулахыг зөвшөөрсөн лиценз эзэмшигчийн албан бичиг тоот
- Гэрээ байгуулсныг нотлох баримт
- Үүсмэл ордын талбайн зураг, солбицол бүхий лицензийн хуулбар
- БОННУ-ний тайлан
- Стратегийн орд бол АМГТГ-ын санал дүгнэлт

**4-р алхам.**

АМГТГ нь

- ААН хооронд байгуулсан Үүсмэл орд ашиглах гэрээ, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцсэн үүсмэл ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг дүгнэлт, шийдвэрийг үндэслэн боломжтой гэж үзвэл үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгоно.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гуравдагч этгээдэдхуулиар хүлээсэн зарим үүргээ гэрээгээр шилжүүлсэн нь Ашигт малтмалын тухай хууль болон Байгаль орчин бусад хууль тогтоомжоор хүлээсэн үүргээсээ чөлөөлөгдөх үндэслэл болохгүй!!!

## 2.3. АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ҮҮРЭГ

### 2.3.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг

1. Тухайн уурхайн эдэлбэрт оршиж байгаа ашигт малтмалыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах;
2. Уурхайн талбайдаа ашигт малтмалын хайгуул нэмж явуулах;
3. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, уурхайн талбайг хугацаанаас өмнө бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн буцаан өгөх;
4. Ашиглалтын үйл ажиллагаа явуулах зорилгоор уурхайн талбайд нэвтрэн орох, дамжин өнгөрөх, шаардлагатай барилга байгууламж барих, түүнийг ашиглах;
5. Уурхайн талбайн гадна орших газар нутгаар дамжин өнгөрөхдөө бусдын өмчлөл, эзэмшилд байгаа газарт түүний өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрсний дагуу нэвтрэх, дайран өнгөрөх;
6. Ашиглалтын үйл ажиллагаа явуулах зорилгоор газар, ус ашиглах, гэрээ байгуулах, тайлагнаж нийтэд нээлттэй байлгах;
7. Ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлдээ тухайн уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, дэд бүтцийг хэрхэн бүрдүүлэх болон уурхайн нөхөн сэргээлт, хаалт зэрэгт шаардагдах хөрөнгийн талаар тодорхой тусгаж батлуулах;
8. АМГТГ-т байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын асуудлаар тогтмол мэдээлэх ажилтантай байх;
9. Газар ашиглах эрхээ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байх.
10. Уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон тухайн сум, дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой үйл ажиллагаа явуулах, зардал гаргах.
11. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компани болон бичил уурхайгаас алт олборлогч нь олборлосон алтаа тухайн санхүүгийн жилдээ багтааж тушаана.
12. Өөрийн үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, туслан гүйцэтгэгч сонгоход тэргүүн ээлжинд стандартын шаардлага хангасан бараа, ажил, үйлчилгээ бүхий Монгол



- Улсад бүртгэлтэй татвар төлөгч ААНБ-д давуу эрх олгоно.
13. Техникийн гэнэтийн осол, саатал, давагдашгүй хүчин зүйл, шүүхийн шийдвэр, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг нь зогсоосон болон бусад шалтгаанаар уурхайн бүтээн байгуулалт, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоохдоо АМГТГ-т д мэдээлнэ.
  14. Олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг МУ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр нийлүүлнэ.
  15. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хаяг, цахим шуудан, утас, факсны дугаар өөрчлөгдсөн тохиолдолд 14 хоногийн дотор УБЕГ болон АМГТГ-т мэдэгдэнэ.
  16. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших гэрчилгээ гарснаас хойш 3 сарын дотор МХЕГ-ын техникийн шаардлагын дагуу уурхайн талбайн хилийг тогтоолгож, байнгын шав тэмдэг тавьж сум дүүргийн комисст хүлээлгэн өгч актыг МХГ-т хүргүүлнэ.
  17. Тусгай зөвшөөрөл нь өөрийн буруугаас дуусгавар болсон нь лиценз эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхайг хаах талаар болон байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу хүлээх үүргээс чөлөөлөхгүй.
  18. Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 3 жил үйл ажиллагаа явуулаагүй бол тусгай зөвшөөрөл дуусгавар болно.
  19. Тусгай зөвшөөрөл дуусгавар болсон талбайд үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.
  20. Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.
  21. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 400 граммаас дээш жинтэй, эсхүл түүнээс хөнгөн боловч онцгой чамин дүрс хэлбэртэй байгалийн төрц алт, түүнчлэн ховор өнгө, дүрстэй эрдэнийн чулуу олборлосон бол тэдгээрийг Монгол банкны төрийн эрдэнэсийн санд урамшуулалтай үнээр худалдах үүрэгтэй.

### 2.3.2. Байгаль орчныг хамгаалах талаар БИЕЛҮҮЛЭХ үүрэг:

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон тухайн жилийн гүйцэтгэх нөхөн сэргээлт, байгаль орчныг хамгаалах зардлын 50 хувьтай тэнцэх дэнчин санхүүжилтийг БОЯ-ны тусгай дансанд байршуулна. Нөхөн сэргээлт хийж, хүлээлгэн өгсний дараа дэнчин хөрөнгийг тухайн жилд нь багтаан буцааж авна.
2. АМГТГ-ын комиссын шийдвэргүйгээр ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа эхлэхийг хориглоно.
3. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь БОННУ болон БОМТ-г шинэчлэн боловсруулж сум, дүүргийн Засаг даргаар батлуулсаны дараа БОЯ-аар батлуулна.
4. Ашиглалтын явцад илэрсэн Соёлын өвийг хамгаалах, хамгаалалтад авахыг холбогдох газар мэдээлэх үүргийг биелүүлнэ.
5. Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан, улсын хяналтын байцаагчид хайгуулын талбайд нэвтрэн орох, газар дээр нь шалгалт хийх бололцоо олгох;
6. БОННУ-ээр тухайн уурхайн ажиллагааны явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлох;
7. БОМТ-д уурхайн ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, агаар мандал болон усны бохирдолт, хүн, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг тусгахаас гадна дараахь зүйлийг тусгах:
  - хортой болон хор хөнөөл учруулж болзошгүй бодис, материалыг хадгалах, хяналт тавих;
  - газрын гадаргуугийн болон гүний усыг хамгаалах, ашиглах, хуримтлуулах;
  - уурхайн хаягдлын далан барих, уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах;
  - уурхайн эдэлбэрт өртсөн газрыг нөхөн сэргээх арга хэмжээ;
  - тухайн уурхайн ажиллагааны онцлогтой холбогдсон бусад арга хэмжээ.
8. БОННУ болон БОМТ-г эцэслэн сум/дүүргийн засаг даргаар батлуулан БОЯ-д хүргүүлж батлуулах;
9. БОННУ болон БОМТ-г батлагдмагц тусгай

зөвшөөрөл эзэмшигч нь тэдгээрийн хуулбарыг тухайн ашигт малтмалын орд байршиж байгаа нутаг дэвсгэрийг харьяалах аймаг, сум, дүүргийн Засаг дарга болон байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

10. Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан сөрөг нөлөөллийг тухай бүр бүртгэж, БОМТ-ний биелэлт болон тайланг жил бүр гарган БОЯ, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд тус тус хүргүүлэх бөгөөд уг тайланд дараахь зүйлийг тусгах:
  - байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;
  - ашигласан шинэ техник, технологи;
  - үйлдвэрийг өргөтгөж хүчин чадлыг нь нэмэгдүүлсний улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнтэй холбогдуулан БОННУ болон БОМТ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал.
11. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтанд уурхайн талбайд нэвтрэн орох, газар дээр нь шалгалт хийх бололцоо олгох;
12. БОЯ нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилийн БОМТ-ний

хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална.

13. Лиценз эзэмшигч нөхөн сэргээлтийн барьцаа мөнгөн хөрөнгийг тухайн жилийн олборлолтын ажил эхлэхийн өмнө шилжүүлэх бөгөөд энэхүү шилжүүлэг хийгдсэн талаар БОЯ тухайн сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэнэ.
14. БОЯ нь лиценз эзэмшигчийн хүргүүлсэн БОНБУ болон БОМТ-г хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан батлах эсэх шийдвэр гаргаж лиценз эзэмшигчид хүргүүлнэ.
15. Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн биелүүлээгүй тохиолдолд БОЯ нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулсан заасан хөрөнгөөр жил бүр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна.
16. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь БОННУ болон БОМТ-д тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол БОАЖЯ-аас байршуулсан дэнчин мөнгөн хөрөнгөө жил бүр буцаан авна.
17. Хэрэв нөхөн сэргээлтийн барьцаа мөнгөн

хөрөнгийг хугацаанд нь шилжүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга уурхайн тухайн жилийн олборлолтын ажлыг зогсоох эрхтэй.

18. Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга болон мэргэжлийн хяналтын алба хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх эрхтэй.
19. Лицензийн хүчин төгөлдөр байх хугацаанд түүнийг эзэмшигч нь шинэ техник, технологи нэвтрүүлснээс байгаль орчинд сөргөөр нөлөөлөх шинэ нөхцөл, байдал үүсвэл БОЯ нь БОННУ болон БОМТ-нд нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардана.

### **2.3.3. Эд хөрөнгийн талаар хүлээх үүрэг, нөхөн олговрын талаар БИЕЛҮҮЛЭХ үүрэг:**

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.

### **2.3.4. Нутгийн захиргааны байгууллагатай харьцах БИЕЛҮҮЛЭХ үүрэг:**

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.
2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.1-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.
3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болно.
4. ЗДТГ нь Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан даруйдаа [www.iltodgeree.mn](http://www.iltodgeree.mn) сайтад байршуулах үүрэгтэй тул энэ цахим сайтад орж үзээрэй.

### **2.3.5. Ажиллах хүчний талаар тавигдах шаардлага, төлбөр, зарцуулалт:**

1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч нь МУ-ын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд

тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно. 10 хүн тутмын 1 нь л гадаадын ажилтан байж болно гэсэн үг.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг дээрх хувиас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө. Хэрэв 10 ажилтан тутамд 1 байхаас илүү 2 болсон тохиолдолд 420,000-ийг 10 дахин нэмэгдүүлсэн буюу 4,200,000 төгрөгийг сар бүр сум/дүүргийн төсөвт төлнө гэсэн үг.
3. Ажиллах хүчний төлбөрийг тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, боловсролын болон эрүүл мэндийн салбарт зарцуулах бөгөөд энэ талаархи журмыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

### **2.3.6. Мэдээ тайлан гаргах, сурталчлан танилцуулах талаар БИЕЛҮҮЛЭХ үүрэг**

1. Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор;

2. Уулын ажлын төлөвлөгөөг батлагдсан зааврын дагуу 12 дугаар сарын 01-ний дотор;
3. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд нөөцийн зэрэглэлийг ахиулах ашиглалтын хайгуулыг тухай бүр хийж, ажлын төлөвлөгөө, тухайн жилийн болон хайгуулын ажлын үр дүнгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор. Тус тайланд:
  - ажилласан өдөр,
  - ажиллагсдын тоо,
  - тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмчлөлтэй холбоотой гэрээ, хэлцэл;
  - уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл,
  - нөөцийн хөдөлгөөний тооцоо,
  - уурхай ажилласан хугацаа,
  - үйлдвэрлэлийн дамжлагын схем, өргөтгөл, шинэтгэлийн ажил;
  - олборлосон хүдэр,
  - үйлдвэрлэсэн, ачуулсан, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ,
  - борлуулсан үнэ, түүнийг худалдан авагчийн тухай мэдээлэл,
  - тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалт, ашиглалтын зардал,
  - ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлсөн болон

## УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

- ашиглаж байгаа тоног төхөөрөмж,
  - бусад хөрөнгийн тухай
  - уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл хангасан ажил
  - тухайн сум, дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах явуулсан үйл ажиллагаа түүний зардлын мэдээг багтаасан байна.
4. БОННУ болон БОМТ ний дагуу авсан арга хэмжээ зарцуулсан зардал, үр дүнгийн тайланг БОЯ-д хүргүүлнэ.
  5. БОМТ ний дагуу авсан арга хэмжээ зарцуулсан зардал, үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй нутгийн иргэдэд, нөлөөллийн бүсийн иргэдэд танилцуулж тайлагнах, дараа жилийн төлөвлөгөөнд санал авах үүрэгтэй.
  6. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээ, Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийн тайланг дараа оны 1 дүгээр улиралд багтаан олон нийтэд мэдээлнэ. Үүсмэл орд ашиглах лиценз эзэмшигч мөн хамаарна.
  7. Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд ажлын төлөвлөгөөг энэ хуулийн 48.6.2-т, тухайн жилийн ажлын тайланг 48.1.2-т заасан хугацаанд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.



## 2.3.7. Тусгай зөвшөөрөл сунгах, дуусах, буцаах, цуцлах

	Сунгалт	Дуусгавар болох	Буцаах		Цуцлах
			Хэсэгчлэн	Бүхэлд нь	
Ашиглалтын лиценз	2 жилийн өмнө мэдэгдэнэ БО ны үүргээ биелүүлж байсан нотлох баримт АМГТГ 15 өдөрт багтаан шийд гаргаж ажлын 7 өдрийн дотор өдөр тутмын сонинд мэдэгдэж сум, дүүргийн ЗД-д мэдэгдэнэ мэдэгдэл авснаас хойш лицензийн төлбөр төлнө.	Лицензийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан. Лиценз эзэмшигч талбайг бүхэлд буцаан өгсөн; Төрөөс цуцалсан Лиценз эзэмшигч нь олгогдсон талбайн тодорхой хэсгийг буцаан өгсөн тохиолдолд уг талбайн хувьд тусгай зөвшөөрөл нь дуусгавар болно. Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 3 жил үйл ажиллагаа явуулаагүй бол тусгай зөвшөөрөл дуусгавар болно.	Тусгай зөвшөөрлийн талбайн тодорхой хэсгийг өөрийн хүсэлтээр буцаан өгч болно. Үлдсэн талбайн хэмжээ 150гектараас их 400 гектарасс багагүй бна. Талбайн тодорхой хэсгийг буцаан өгсөн нь өмнө төлсөн тусгай зөвшөөрлийн төлбөрийг бууруулах, эсхүл түүнийг буцаан олгох үндэслэл болохгүй.	Лицензээр олгогдсон талбайг өөрийн хүсэлтээр бүхэлд нь буцаан өгч болно. АМГТГ нь тухайн лицензээр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан авсан тухай зохих байгууллагад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Лицензийн төлбөрөө 30 хоногт багтаан бүрэн төлөөгүй бол цуцлана.</li> <li>Уурхайн талбайг энэ хуулийн 13.1.3-т заасны дагуу нөөц болон тусгай хэрэгцээнд авч, эсхүл тухайн талбайд ашигт малтмал хайх, ашиглахыг хуулиар хориглож нөхөн олговрыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүрэн төлсөн</li> <li>Байгаль орчинд хортой нөлөөлж байгаа, эсхүл нөхөн сэргээх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захиргааны байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргасан</li> <li>«Урт нэртэй хууль»-ийн хүрээнд ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зүйл, заалт болон хуулийн дагуу байгуулсан гэрээний заалтыг зөрчсөн</li> <li>Лицензээ холбогдох хуулийн дагуу шилжүүлсэн бол;</li> <li>Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараа аргачлалын дагуу тайлагнаагүй, эсхүл үнэлгээ тооцоход шаардагдах мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулсан, худал мэдүүлж тайлагнасан;</li> <li>Лиценз эзэмшигч өөрийн компаний эцсийн эзэмшигч хувь хүний мэдээллийг татварын албанд мэдээлээгүй эсвэл хуурамч мэдээлэл өгсөн бол цуцална;</li> <li>АМГТГ ашиглалтын болон үүсмэл орд ашиглах лицензийг цуцалсан бол ТЕГ-т УМХГ-т мэдэгдэж өдөр тутмын сонинд зарлана.</li> </ul>

### 2.3.9. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээлэлтэй танилцах, мэдээлэл авах

1. Сонирхсон этгээд тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлтэй ажлын цагаар зориулалтын байранд танилцах эрхтэй.

2. Бүх шатны ИТХ-ын төлөөлөгч өөрийн албан бланкаар хүсэлт гаргаж АМГТГ, БОАЖЯ, МХЕГ-аас албан ёсны мэдээлэл авах боломжтой.

3. БОННУ болон БОМТ, тайлан, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж болзошгүй химийн хорт болон бусад бодисын хэрэглээний талаархи мэдээллийг БОАЖЯ болон МХЕГ нийтэд нээлттэй болгож, тухайн мэдээллийг цахим хэлбэрээр түгээнэ.

4. Үндсэн хууль болон Байгаль хамгаалах хуульд зааснаар иргэн хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй холбоотой асуудлаар холбогдох үнэн бодит мэдээлэл авах эрхтэй.

5. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд зааснаар иргэн нь мэдээлэл авах болсон шаардлага, үндэслэлээ тайлбарлахгүй байх эрхтэй.

### 2.4. КОМПАНИЙ ЗҮГЭЭС НУУЦЛАХЫГ ХОРИГЛОСОН МЭДЭЭЛЭЛ

1. Тухайн ААН-ийн явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл заавал нээлттэй байна.

2. Тухайн ААН-ийн мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл заавал нээлттэй байхаар Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуульд онцлон заасан байдаг.



## 2.5. ЭНЭ МӨЧЛӨГ ДЭХ БИЧИГ БАРИМТУУД

**АМ-ын ордыг ашиглах лиценз эзэмшигч ААН-үүдийн уурхайн объект дээр байлгах ёстой бичиг баримтын жагсаалт, тэдгээрээс авч болох мэдээлэл**

	<i>Баримт бичиг</i>	<i>Танилцагч юу хэрхэн харах вэ</i>
1	ААН-ийн гэрчилгээний хуулбар УБЕГ-ын хуулийн этгээдийн бүртгэлийн газраас олгосон гэрчилгээ.	Хуулийн этгээдийн үйл ажллагааны чиглэлийг оноор харах Ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан огноотой тулгаж харах  ААН-ийн эцсийн ашиг хүртэгч хувь иргэн түүний холбогдох мэдээллийг харах
2	Тусгай зөвшөөрлийн хуулбар	Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон огноо, сунгасан огноо, талбайн солбицол
3	Лицензийн төлбөр төлсөн баримт	Анхан шатны баримтаас тухайн жилийнх байгаа эсэх
4	Орд ашиглах ТЭЗҮ	ТЭЗҮ огноо, түүнээс зам дэд бүтцийн гм олон мэдээлэл харж болно
5	Нөөцийг бүртгэлд авсан ЭБЗ-ийн хурлын протокол	Эрдмийн зөвлөлийн шийдвэрийн огноо, нөөцийн хэмжээ, борлуулах зах зээл, түүнд хүргэх авто тээврийн замыг хэрхэн шийдэхээр тусгасан байна.
6	Нөөц бодсон геологийн дэвсгэр зураг	Лицензтэй талбайдаа байгаа эсэх нөөцийн хэмжээ
7	Үнэт металл олборлолтын журнал	тогтмол хөтөлгөө батлагаажуулалт
8	Ашиглалтын үеийн геологи маркшейдэрийн бичиг баримт	Соёлын өв болон палентологийн судалгааны дүгнэлт тайлан, хөтөлгөө
9	Сар улирлын гүйцэтгэлийн мэдээлэл	Үйл ажиллагааны тэмдэглэл, баталгаажуулалт
10	АМНАТ төлсөн бичиг	төлсөн огноо тухайн жилийнх эсэх

## УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

11	Төсвийн хөрөнгөөр нөөц тогтоосон орд бол хайгуулын зардлыг улсын төсөвт төлсөн гэрээ	гэрээний огноо, нээлттэй байршуулсан бол линкийг үзэх
12	Ажлын нарядын дэвтэр	Ажиллах хүчний мэдээлэл,
13	Аваар устгах төлөвлөгөө	Төлөвлөгөөний хэрэгжилт, тайлан, батлагаажуулалт
14	Тэсэлгээ явуулах зөвшөөрөл	Ямар хугацаанд, мэргэжлийн ямар байгууллагаар хийлгэх, орчны бүс дэх иргэд, малчдад хэрхэн мэдээлсэн тайлан
15	Өрөмдлөг тэсэлгээний ажлын паспорт	Тэсэлгээний хадгалалт, хамгаалалт, хөтөлгөө, тэсэлгээний бодисын зөвшөөрөл гм
16	ХХАА-ны зааварчилгаа сурталчилгааны төлөвлөгөө	Жил бүрийн төлөвлөгөө, тайлан, баталгаажуулалт
17	Өнгөрсөн жилийн уулын ажлын гүйцэтгэл тайлан	Жил бүрийн төлөвлөгөө, тайлан, баталгаажуулалт
18	Ашиглаж дууссан блок хаасан тухай баримт	Комиссын дүгнэлт, тайлан, баталгаажуулалт
20	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	БОАЖЯ-аас жил бүрийн байгаль орчны үүрэг, нөхөн сэргээлт хийх ажлын зардлыг тогтоосон хэмжээг заавал харах. Жил бүрийн төлөвлөгөө, тайлан, баталгаажуулалт. Үүнээс ЗД батласан эсэх, олон нийтэд танилцуулах, нөхөн төлбөр олгох арга хэмжээний хэрэгжилт
21	БОНБНУ + нэмэлт + тодотгол	БИНХ-ын тогтоол, тэмдэглэл, ирцийн бүртгэл байгаа эсэх бодитой юу. Ямар химийн бодис хэрхэн ашиглах талаар гм өргөн хүрээтэй маш олон мэдээлэл авах боломжтой

22	БОХ барьцаа хөрөнгө 50%-ийг байршуулсан баримт	БОАЯ-ны тусгай дансанд байршуулсан, буцаан авсан баримт, жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөтэй уялдаж өөр өөр дүнтэй байх ёстойг анхаарах
23	Нөхөн сэргээлт хийснийг хүлээж авсан акт, комисс	Аймаг, сумаас томилогдсон Ажлын хэсгийн акт бүрэлдэхүүн, бодитой эсэх
24	Газар ашиглах гэрээ төлбөрийн мэдээлэл	Авсан газар нь тухай жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан эсэх, газрын гэрээний нөхцөл шаардлага болон түүний хэрэгжилт
25	Ус ашиглах гэрээ төлбөрийн баримт	Хоногт хэрэглэх усны хэмжээ, дүгнэлт гаргасан байгууллага, ашигласан болон бохирдуулсан усны төлбөр, усны төлбөрөөс чөлөөлсөн үндэслэл, усны тоолуурын хэрэглээ, лац, саарал ус ашиглаж байгаа бол технологи тасралтгүй ажиллаж байгаа эсэх
26	Уурхайн эдэлбэрт шав тэмдэг тавьсан акт	уурхайн эдэлбэрт газар, үйлдвэрлэлийн бүсийг аюул эрсдэлээс сэргийлсэн шав тэмдэг анхааруулгыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хүлээлгэн өгсөн акт огноо, бодит байдалтай харьцуулан харах
27	Лиценз эзэмшигчийн өмчлөх эрхийг хөндсөн бүх төрлийн гэрээ хэлцэл	Газрын гэрчилгээг өмчин эрхийн бүртгэлд бүртгүүлсэн эсэх
28	Тухайн орон нутагтай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээ түүний дүгнэлт	Гэрээ байгуулсан огноо, хугацаа, сан хандивын зохицуулалт, тайлагнал, дүгнэсэн акт. Гэрээг байгуулахын өмнө ЗЕХ-ын дагуу сонсох ажиллагаа явуулсан эсэх, нөлөөллийн бүсийн иргэдийг оролцуулсан эсэх
29	Орон нутгаас ажиллаж байгаа хүмүүсийн судалгаа	Нийт ажиллах хүчний тоо, үүнээс гадаад ажилтны аймаг сумаас ажиллаж байгаа ажилтны тоог НДШ-ийн тайлангийн нэрстэй тулгаж харах
31	Байгаль орчны аудитын тайлан дүгнэлт	3 жил тутатмд хараат бус этгээдээр хийлгэсэн, түүнийг баталсан, тайлангаар өгөгдсөн зөвлөмж дүгнэлт түүний мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө тайлан, олон нийтэд мэдээлсэн байдал
32	Бусад	

### 2.6. ЭНЭ ШАТАНД ОЛОН НИЙТ, ИРГЭНИЙ ОРОЛЦОО

МУ-ын Үндсэн хуулийн 6-р зүйлийн 6.2 дахь хэсэгт “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.” гэж 2019 оны 11 сарын нэмэлт, өөрчлөлт орууллаа.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн үе шатанд иргэд, нутгийн хамт олны оролцооны эрх хайгуулын үе шаттай харьцуулахад илүү өргөн боломжтой байдаг нь давуу тал боловч илүү мэдлэг, мэдээлэлтэй байх, тогтвортой ажиллахыг шаарддаг.

Үүний тулд, заавал оролцох шаардлагатай хэдэн үйл ажиллагааг онцлоё.

1. Сумын Засаг даргын орлогч даргаар ахлуулсан Олборлох салбарын ил тод нээлттэй байдлыг хэрэгжүүлэх сумын дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах. Үүний тулд Ашигт малтмалын тухай хуулийн 48-р зүйлийн 48.10 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны 222-р тогтоолд заасан төрийн байгууллага, компаний үүргийг мэдэж аваарай.

2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь жил бүрийн 1-р улиралд багтаан өнгөрсөн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон

орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хандив дэмжлэгийн хэмжээ, Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийн тайлан, сум орон нутгаас ажиллуулсан ажиллах хүчин, нөхөн сэргээлт түүний зардал, нөхөн төлбөр өгсөн хэн хэнд ямар хэлбэрээр зэрэг мэдээллийг бичгээр болон тайлан танилцуулга хийх үүрэгтэй. Энэ арга хэмжээнд заавал оролцоорой.

3. Ашигт малтмалын тухай хуулийн 42-р зүйлийн 42.1 дэх хэсэгт заасан дагуу Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сумын ЗДТГ-ай байгуулах Хамтын ажиллагааны гэрээ ХОРОО-нд төлөөллөө оруулж ажиллах хэрэгтэй.

4. Энэхүү Хамтын ажиллагааны гэрээг ард түмний нэрийн өмнөөс Засаг дарга компанитай хэлцэл хийж байгаа тул Захиргааны ерөнхий хуульд зааснаар захиргааны гэрээ болох учир эрх ашиг нь хөндөгдөх иргэдийг, ялангуяа уурхайн багийн нөлөөллийн бүсийн иргэдийн санал, тайлбарыг авах сонсох ажиллагаа заавал явуулна. Иймд иргэд, ТББ сонсох ажиллагаа зарлагдсан тохиолдолд заавал оролцоорой. Харин үүний өмнө Хамтын ажллагааны гэрээний төслийг авч сайтар танилцсан байх шаардлагатай.

5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд

дундаасаа сонгон ажиллуулж болох тухай АМТХ-ын 42.2 дахь заалтад заасныг ашиглах боломжтой.

- Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших эрхийн гэрчилгээ гарснаас хойш 2 сарын дараагаас дээр дурьдсан үүргүүдийн хэрэгжилт, холбогдох бичиг баримтуудыг авч үзэх, танилцах, олон нийтэд танилцуулахыг баг, сумын Засаг даргадаа уламжлаарай.

- Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компани нь жил бүр БОМТ-ний хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг нутгийн иргэд, нөлөөллийн бүсийн иргэдэд бусад хүссэн талуудад нээлттэй мэдээлж танилцуулах үүрэгтэй. Энэ арга хэмжээнд заавал оролцох бөгөөд хэрвээ компани энэ үүргээ хэрэгжүүлэхгүй бол тайлагнахыг компаниас болон сумын БО-ны байцаагч, Засаг даргаас гарын үсэг зурж тайланг батлахгүй байхыг шаардах хэрэгтэй.

- Сумын ИТХ-аар жил бүрийн эцэст тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж дүгнэлт гаргаад дараа жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баталж тогтоол гаргаж, Засаг дарга хэрэгжилтийг хангадаг. Иймд энэ Газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь Захиргааны ерөнхий хуульд зааснаар Бодлогын ТӨЛӨВЛӨЛТ болох учир мөн сонсох ажиллагаа явуулах ёстой. Иймд Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн жилд ашиглаж, эзэмших газрынхаа хүсэлтийг сумын ЗД-д хүргүүлж ирэх жилийн төлөвлөгөөнд оруулдаг тул танай багийн хаана ямар компани хэдий хэмжээний газрын зөвшөөрөл авч байгааг мэдэж авснаар хариуцлага шаардах, хяналт тавих замаар оролцооны эрхээ хэрэгжүүлэх боломжтой болдог. Хэрэв сонсох ажиллагаа хийхгүй бол та шаардаарай.



## УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

АШИГТ МАЛТМАЛЫН ХУЧИН ТӨГӨЛДӨР ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОО, ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, НИЙТ НУТАГ ДЭВСГЭРТ ЭЗЛЭХ ХУВЬ, *аймгаар, 2020.1.31*

БҮГД	БҮГД			Үүнээс:					
	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	Ашиглалт			Хайгуул		
				Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	Тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /мян.га/	Нутаг дэвсгэрт эзлэх хувь
<b>БҮГД</b>	<b>2,782</b>	<b>7,309.5</b>	<b>4.7%</b>	<b>1677</b>	<b>1,639.5</b>	<b>1.0%</b>	<b>1105</b>	<b>5,670.1</b>	<b>3.7%</b>
Архангай	21	60.6	1.1%	15	6.2	0.1%	6	54.4	1.0%
Баян-Өлгий	60	179.9	3.9%	28	15.4	0.3%	32	164.5	3.6%
Баянхонгор	147	355.5	3.1%	93	124.3	1.1%	54	231.2	2.0%
Булган	109	131.7	2.7%	74	35.7	0.7%	35	95.9	2.0%
Өвөрхангай	48	136.0	2.2%	28	15.7	0.2%	20	120.4	1.9%
Говь-Алтай	145	706.6	5.0%	50	73.5	0.5%	95	633.2	4.5%
Говьсүмбэр	18	45.6	8.2%	13	38.9	7.0%	5	6.7	1.2%
Дархан-Уул	68	12.7	3.9%	62	7.6	2.3%	6	5.1	1.6%
Дорноговь	345	1,261.5	11.5%	189	235.8	2.2%	156	1,025.8	9.4%
Дорнод	154	514.1	4.2%	73	63.0	0.5%	81	451.1	3.7%
Дундговь	203	700.3	9.4%	106	182.6	2.4%	97	517.7	6.9%
Завхан	52	263.8	3.2%	9	14.1	0.2%	43	249.8	3.0%
Өмнөговь	177	1,109.7	6.7%	93	448.4	2.7%	84	661.3	4.0%
Орхон	9	11.1	13.2%	9	11.1	13.2%	0	0.0	0.0%
Сүхбаатар	94	294.2	3.6%	67	59.8	0.7%	27	234.4	2.8%
Сэлэнгэ	180	97.6	2.4%	141	42.9	1.0%	39	54.7	1.3%
Төв	397	371.8	5.0%	300	153.8	2.1%	97	218.0	2.9%
Увс	130	424.3	6.1%	49	21.4	0.3%	81	402.9	5.8%
Улаанбаатар	172	14.7	3.1%	160	13.3	2.8%	12	1.4	0.3%
Хөвсгөл	26	17.0	0.2%	21	10.3	0.1%	5	6.7	0.1%
Ховд	102	261.7	3.4%	35	14.0	0.2%	67	247.7	3.3%
Хэнтий	216	339.1	4.2%	120	52.0	0.6%	96	287.1	3.6%

Эх сурвалж: Кадастрын хэлтэс, АМГТГ



## ГУРАВДУГААР БҮЛЭГ

# ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ХҮНДЛЭХ ТӨРИЙН БОЛОН БИЗНЕСИЙН ҮҮРЭГ

- Хүний үнэ цэнэ
- Хүний эрх, эрх чөлөө
- Хүний эрхийн Хамгаалалт
- Эмэгтэйчүүдийн эрх



## 3. ХҮНИЙ ҮНЭ ЦЭНЭ

### 3.1. ХҮНИЙ АМЬДРАЛЫН ҮНЭ ЦЭНИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Нэгэн уран илтгэгч 200 хүн цугласан том танхимд илтгэл тавьж байв. Тэрээр гэнэт 20 мянгатын мөнгөн дэвсгэрт гаргаж ирээд хэн нэгэн үүнийг авахыг хүсч байгаа эсэхийг асуухад бүгд гараа өргөв. Илтгэгч “Энэ мөнгийг та нарын хэн нэгэнд өгөх болно. Харин өмнө нь нэг зүйлийг хийх хэрэгтэй” гээд 20 мянган төгрөгөө нугалж үрчийлгэн, базаж байснаа дахиад л авахыг хүсч байгаа эсэхийг асуухад хүмүүсийн гар мөн л өргөөтэй байлаа.

Илтгэгч нөгөө мөнгийг газар шидээд дээрээс нь дэвсэж, үрчийлгэн бүр шороотой хольж хутгаснаа ахиад л нөгөө асуултаа давтав. Гэвч бүх хүн тэр мөнгийг авахыг хүсч байлаа. Харин энэ үед илтгэгч: Энэ бүхний эцэст, бид нэг зүйлийг ойлгоно. Энэ бол үнэ цэнэ. Ингэж ярьж байгаагийн гол утга нь би энэ мөнгийг үрчийлгэж, базалж, дэвсэлсэн ч энэ бүхэн түүний үнэ цэнийг алдагдуулахгүй. Тэр одоо ч 20 мянган төгрөг хэвээрээ.

Бидний амьдралд хэн нэгэнд гомдох, өөрийгөө хэнд ч хэрэггүй гэж бодох, сэтгэлээр унах зэрэг янз бүрийн зүйл тохиолддог ч бид өөрийн үнэ цэнийг алдах ёсгүй. Хамгийн гол нь чамд хайртай хүмүүс үргэлж чиний хэн болохыг санаж байдаг. Амьдралын үнэ цэнэ гэдэг бидний юу хийсэн, хэнийг таньдаг зэргээр хэмжигддэггүй. Харин бидний хэн болохыг тодорхойлдог.

<http://www.sonin.mn/news/culture/12181>



**Хүний эрхэм чанар:**

- Хүн бүрт адилхан заяагдсан
- Хүн бүрийг хэн байхаас нь үл хамааран хүнийх нь хувьд хүлээн зөвшөөрч хүндлэх
- Хүний эрх, эрх чөлөөний үндэс юм

Хүн бүрт эрхэм чанар бий гэдэг нь хүн бүрийн амьдрал адилхан үнэ цэнэтэй гэсэн үг. Тэгэхээр Хүний амьдралын үнэ цэнэ бол:

**3.2. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ**

Дэлхийн хаана ч хүн бүхэн амьдрах, амьд явах эрхтэй.

Ингэхдээ гарал үүсэл, үндэс угсаа, арьсны өнгө, шашин шүтлэг, эрэгтэй, эмэгтэй, хэл зэргээс үл шалтгаалан аливаа шударга бус, ялгаварлан гадуурхалтанд өртөх ёсгүй.

Хүний эрх гэдэг нь ямар нэг давуу эрх, онцгой ямбыг илэрхийлсэн ухагдахуун биш учраас:

- аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид эрх тэгш байх,
- шударга байх,
- халдашгүй, эрх чөлөөтэй орших,
- үнэ цэнээ ойлгож өөрийгөө хүндлэх,
- бүтээлчээр өсч хөгжих зэрэг хувь хүний эрх байдаг бол нийгэм, хамт олны дунд зохицож амьдрах, бусдын эрхийг өөрийн эрхтэй

Амьдрах, амьд явах	Биологийн хувьд оршин тогтнохын тулд хичээх
Эрхэмсэг орших	Нэр төр, үнэ цэнээ мэдрэх
Халдашгүй байх	Оюун санаа, бие махбодын хувьд бүрэн бүтэн байдлаа хадгалах
Эрх чөлөөтэй байх	Хэнээс ч хамааралгүй, хараат бусаар эрх чөлөөтэй өөрийнхөө амьдралыг сонгож бүтээгч,

адилтган ойлгож хүндэтгэлтэй хандах, бусдад зүрх сэтгэлээсээ хандаж хувь нэмэр оруулдаг байх наад захын стандартууд хүн төрөлхтөний түүхэнд үеэс үед уламжлагдсаар ирсэн.

Тэгэхээр хүний эрх, эрх чөлөө гэдэг нь:

- а) хүнд өөрт нь байдаг төрөлх чанарыг илэрхийлсэн, ертөнцийн зарчмуудад суурилсан гүн ухааны ойлголт, ухагдахуун;
- б) хүнийг өөрийг нь хамгаалах стандарт;
- в) эрхзүйн хамгаалах арга хэрэгсэл;
- г) эрх мэдлийн хэмжүүр юм.

Өөрөөр хэлвэл, хүн байгал, нийгмийн бүтээгдэхүүний хувьд амьд явах, амьдрахад шаардлагатай хоол, унд, хувцас хунар, орон гэртэй байх гэх мэт наад захын хэрэгцээгээ хангах боломж, түүнийг эдлэх баталгааг хэлдэг.

**Хүний эрхийн үндсэн зарчмууд:**

Заяамал, салшгүй	Хүний эрх нь аль ч үндэстний хувьд төрөлх, заяамал бөгөөд хүнээс тусгаарлаж салгах боломжгүй
Түгээмэл	Хүний эрх нь ертөнцийн өнцөг буланд амьдарч байгаа хүн бүрт хамаатай
Тэгш эрхийн	Бүх эрхүүд ижил үнэ цэнэтэй, ижил тэнцүү ач холбогдолтой учир ижил түвшинд хамгаалагдах, хангагдах ёстой.
Ялгаварлалгүй байх	Хэн нэгнээс өөр байгаагаараа ялгаварлагдаж гадуурхагдах ёсгүй.
Халдашгүй, чөлөөтэй байх	Хөндлөнгийн хэн боловч дур мэдэн эрх, эрх чөлөөнд халдах ёсгүй
Хуваагдашгүй, шатлалгүй	Нэг эрх нь нөгөө эрхээсээ чухалд тооцогдох, дээгүүр эсвэл доогуур тавигдах ёсгүй.
Цогц, харилцан уялдаа хамааралтай	Хүний эрхүүд нийлээд цөм болж байдаг хоорондоо харилцан хамааралтай, уялдаа холбоотой. Хүмүүс аюулгүй байх эрхээ эдлэхгүйгээр хөгжих эрхээ эдлэх боломжгүй. Нэг төрлийн хүний эрхийг хангах явц сайжрахад өөр эрхийг эдлэх боломж илүү бүрддэг. Аль нэг эрх зөрчигдөхөд бусад эрхүүдэд нөлөөлдөг.

**3.3. ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАЛТ**

Хамгаалалт /стандарт, эрх зүйн хамгаалалт болон бусад/ гэмээр байна. Ингэж байж харилцан хамаарал уялдаа холбоо, системтэй болно.

Хүн бүр яс үндэс, нас, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, нийгмийн гарал, эдийн засгийн боломж болон бусад байдлыг үл харгалзан ямар ч ялгаварлалгүйгээр, өөрийнхөөрөө амьдралаа зохион, хэнээс ч хараат бусаар амьдрах нь хүний төрөлх чанар юм бол үүнийгээ:

- хэрхэн хамгаалах вэ?
- хэн хамгаалах вэ?
- Яаж хамгаалах вэ? гэсэн асуулт зүй ёсоор тавигдана.

Хүний эрх аливаа нэг төр, шашин, хууль, засаглалын ямар нэг тогтолцооноос олгогдож зөвшөөрөгддөг эд биш. Угаас төрөхөөс өөрт нь заяагдсан болохыг дээр өгүүлсэн билээ.

Хүн хэдийгээр байгалийн амьтан хэдий ч ухамсарт амьтаны хувьд хүний нийгмийг бий болгож зохицон амьдрах шаардлагатай болсон. Өөрөөр хэлвэл хүн хүссэн ч, эс хүссэн ч нийгмийн харилцаанд орж нийгмийн бүтээгдэхүүн болж хүний нийгмийг хөгжүүлж эхэлсэн.

Ингэх явцдаа хүмүүс өөрийн салшгүй төрөлх эрхийг хамгаалахын тулд ямар нэгэн механизм хэрэгтэй болсон.

Тэр нь ТӨР-ийг бий болгосон явдал юм.

Төр нь хүний эрхэм чанар, үндсэн эрх, эрх чөлөөнд харш аливаа үйлдлээс хүнийг хамгаалахын тулд хууль, дүрэм гаргаж түүнээ мөрдүүлдэг.

Хүн байгалаас заяасан эрх, эрх чөлөөгөө эдэлж, эрхэм чанараа мэдрэн, төрөлх чадамжаа ашиглан аз жаргал, амар амгаланг бүтээхийн тулд хүний эрхийг олон улсын болон үндэсний эрх зүйн хэрэгсэл болгон хөгжүүлж байгаа түүх олон мянган жилийн замыг туулсан ч одоог хүртэл сайжруулах, боловсронгуй

болгох хэрэгцээ шаардлага байсаар байна.

Төр нь хувь хүмүүсийн эрхэм чанар сайн сайхан байдлыг хамгаалах үндсэн зорилготой бөгөөд хүмүүсийг айх аюулгүй, халдашгүй, амар тайван, аз жаргалтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө төрийн бодлого, хууль тогтоомжийг боловсруулан гаргаж мөрдөх, хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Өөрөөр хэлвэл, зарим тохиолдолд хүний эрхийг хамгаалахын тулд цагдаа, шүүх зэрэг албадлага хэрэглэдэг үйлчилгээний байгууллага юм.

### 3.4. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

#### ДЭЛХИЙН СТАТИСТИКТ “ЭМЭГТЭЙЧҮҮД”

- Нийт газар эзэмшигчдийн 1%
- Ядуурлын түвшинд амьдарч буй 1 тэрбум хүний 70%
- Нийт эмэгтэйчүүдийн 47% нь хөдөлмөр эрхэлж, эрэгтэйчүүдээс 25-45% бага хөлс авдаг
- Хөлсгүй хөдөлмөрийн 62%
- 173 улсын 155 улсад эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломжийг хязгаарласан эрх зүйн зохицуулалт ядаж 1 байна.
- Нийт менежерийн 21%
- 1000 компаны 110 нь эмэгтэй эзэнтэй.
- Нийт Парламентийн гишүүдийн 22%
- Өдөр бүр төрхийн хүндрэлээр 1440 эмэгтэй нас барж байна.
- 3 эмэгтэй тутмын 1 нь аль нэг хүчирхийлэлд өртдөг.
- Амь насаа алдсан эмэгтэйчүүдийн 38% хамтран амьдрагчийнхаа гарт амь үрэгджээ.

## Нэг. ОЛОН УЛСЫН БОЛОН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖООР ХАМГААЛАГДСАН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХ

НҮБ байгуулагдсан цагаасаа одоог хүртэл эрэгтэй, эмэгтэйчүүд ЭРХ ТЭГШ юм гэдэг хүний үндсэн эрхийг Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал /ХЭТТ/-аар баталгаажуулсан хэвээрээ байгаа.

1945 онд НҮБ дүрмэндээ **“хүн бүр төрхөөс нэр төртэй, үнэ цэнэтэй учир эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй”** гээд “арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэгээр үл ялган хүний эрх, хэн бүхний үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх”

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн бүрэн эрхийн мандатын 13-р зүйлд **“Хүйсэд суурилсан ялгаварлан гадуурхалтыг хориглоно”** гэж заасан.

Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын Пактаар эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалсан байдаг.

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенци (ЭЯГБХУТК) -1979 онд батлагдсан, одоогоор 200 орчим улс хүлээн зөвшөөрч нэгдсэн ба Монгол Улс 1981 онд соёрхон баталсан. Энэхүү конвенциор “эмэгтэйчүүд ялгаварлан гадуурхалтанд өртөж тэгш бус байдалд амьдарч аж төрж байна” гэж үзсэн.

Бүсийн арга хэрэгсэл

- Европын Холбоо, Латин Америк, Африкийн гэх мэт
- Ази Номхон далайн орнуудын Бүсийн хамтын ажиллагааны байгууллагууд, /түүний дотор Зүүн болон Төв Азийн хамтын ажиллагааны нийгэмлэг/
- Хөгжлийн хамтын нийгэмлэгээс гаргасан протокол, шийдвэрт эмэгтэйчүүдийн хүний эрхтэй холбоотой гаргасан мэдэгдэлүүд

## Хоёр. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХЭД ХАМААТАЙ ДЭЛХИЙ ХАМТЫН НИЙГЭМЛЭГҮҮДИЙН ШИЙДВЭР

### 1. Венийн Тунхаглал ба Үйл ажиллагааны

*хөтөлбөр /1993 оны 6 сар, Вена/*

Хүний эрхийн Дэлхийн Бага хурал 100 заалт бүхий “Венийн Тунхаглал, Үйл Ажиллагааны Хөтөлбөр” батлагдаж аливаа хүний эрхийн зөрчлийг арилгахад чиглэсэн баримт бичиг болсон онцлогтой.

Тунхагийн В. бүлэг нь “тэгш байдал, нэр төр, хүлээн зөвшөөрөх” 3-р хэсэг нь: Охид, Эмэгтэйчүүдийн эрх бол хүний эрх юм гээд

- Эмэгтэйчүүдийн эрх зөрчиж буйг үл ойшоож байгааг

- Эмэгтэйчүүдийн эсрэг хвчирхийллийн асуудал,
- эмэгтэйчүүдийн аж байдлын асуудал,
- эмэгтэйчүүд болон уламжлалт ёс заншлын хор хөнөөлийн үр дагавар зан заншил, шашны хэт даврах үзэл

## 2. “Хүн ам ба Хөгжил” Олон Улсын Чуулга

**Уулзалт** /1994 оны 9 сар, Кайро/

- Түгээмэл боловсрол (бүх нийтэд Нөхөн үржихүйн талаар суурь боловсрол эзэмшүүлэх)
- Нярайн болон хүүхдийн эндэгдлийг бууруулах
- Эхийн эндэгдлийг бууруулах
- Гэр бүл төлөвлөлт бүхий бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж

Үүнээс хойш:

- Эмэгтэйчүүдийн тухай
- Охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, НҮЭМ, төрөлт түүнийг хянах
- Гэр бүл, гэр бүл төлөвлөлт,
- ХДХВ/ДОХ
- Бэлгийн цөөнх
- Охид, Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн хвчирхийлэл
- Эмэгтэйчүүдийн цагаачлал, шилжин суурьших асуудал

- Охид, Эмэгтэйчүүд/залуучуудын боловсрол
- Эмэгтэйчүүдийг чадваржуулах
- Суурьшил хөгжлийн асуудал

## 3. Бээжингийн Тунхаг болон Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр /1995 оны 9 сар, Бээжин /

Эмэгтэйчүүдийн хүний эрхийн баталгаа болон ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ЭРХ МЭДЭЛЖҮҮЛЭХ гэсэн зорилгыг агуулсан Дэлхийн Эмэгтэйчүүдийн Их хурал.

- Эмэгтэйчүүдийн эрхийг хүндэтгэх, сөрөг хэвшмэл ойлголт, зан заншлыг халах
- эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг арилгах, эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш байдлыг хангах
- Эмэгтэйчүүдийн амьдралын баталгаа, хөдөлмөр эрхлэлт,

2005, 2010 оны хурлаар хэрэгжилтийг хангахад Улс орнуудын үүрэг амлалтыг нэхэх, Эмэгтэйчүүдийн эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн:

- De facto тэгш байдал
- Хуульчлах, хэрэгжүүлэх
- улс төр, шийдвэр гаргах түвшний оролцоог тодорхойлсон.

### 5. Тогтвортой Хөгжлийн Зорилго – 2016–2030

/SDG/ 2012 он, Рео дэ Жениора, Бразил

Улс орнуудын өмнөх үүрэг амлалтуудын хэрэгжилтийг хурдасгах, эцэслэн шийдвэрлэх 3 тулгуурт зарчим /нийгэм, эдийн засаг, байгаль орчин/, 5 элемент /хүн төрөлхтөн, эх дэлхий, хөгжил цэцэглэлт, энх тайван, түншлэл / бүхий 17 зорилго, 169 зорилт, 244 үзүүлэлттэй хөтөлбөр баталсан.

- Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах /5 –р зорилго нь 9 зорилт, 14 үзүүлэлттэй/
- Удс төр, эдийн засаг, нийгэм соёлын хүрээнд эмэгтэйчүүд шийдвэр гаргахад тэгш эрхтэй оролцох оролцоо, манлайлал, боломж, бололцоо,

### Гурав. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ХАНГАХЫН ТУЛД НҮБ-ЫН БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ

#### 1. Хүний эрхийн Хороо буюу хэрэгжүүлэх механизм

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 47 орны төлөөлөл бүхий энэ Хороо Хүний эрх болон Эмэгтэйчүүдийн хүний эрхийн зөрчлүүдийг арилгахын төлөө:

- Охид, Эмэгтэйчүүдийн эрхтэй холбоотой хууль тогтоомжууд, заавар зөвлөмжүүд гаргах
- Тусгай илтгэгч нараар дамжуулж хяналт үнэлгээ хийх
- Охид, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлуудыг тодорхойлж зөрчлийг арилгах арга хэмжээ авах
- Охид, Эмэгтэйчүүдийн эрхийг хангах, хамгаалахыг Улс орнуудад шаардах
- Улс орнуудын Тайланг хэлэлцэх

#### 2. Аюулгүйн зөвлөл

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл 2000 онд охид, эмэгтэйчүүдийн энх тайван, аюулгүй байдалд хамааралтай 1325 дугаар тогтоолыг санал нэгтэйгээр баталсан.

- Улс орнууд энх тайван, аюулгүй байдлыг хангах нь бүх талуудын хүчин чармайлт юм. Аливаа гэрээ, хэлэлцээр, хэрэгжилтийг хангахдаа хүний эрх, түүний дотор охид, эмэгтэйчүүдийн эрхийг онцгойлон авч үзэхийг шаардсан.
- Зөрчил мөргөлдөөнд оролцогч бүх талууд эмэгтэйчүүд, охидыг хамгаалах тусгай арга хэмжээ авахыг шаардсан
- Жендэрт суурилсан хүчирхийллээс үүдэлтэй охид, эмэгтэйчүүд, хүүхдийн аюулгүй байдлыг хангахыг улс орнуудад үүрэг болгосон.

### 3. Эмэгтэйчүүдийн аж байдлыг дээшлүүлэх Комисс

1946 онд НҮБ-ын эдийн засаг, нийгмийн зөвлөлийн шийдвэрээр байгуулагдсан энэ Комисс нь:

- Засгийн газар, Иргэний нийгэм, ТББ, бусад оролцогч талуудыг өргөн оролцоон дээр үйл ажиллагаагаа явуулдаг
- Улс төр, эдийн засаг, иргэний, нийгмийн болон соёлын салбарт эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад чиглэсэн янз бүрийн асуудлаар чухал шийдвэрүүдийг гаргадаг
- Комисс жилд нэг удаа хуралдаж, тэргүүлэх асуудлуудын талаар үнэлгээ дүгнэлт өгч

яаралтай шийдвэрлэх шаардлагатай асуудлыг хэрэгжүүлдэг.

- Түүхийн туршид Комисс нь эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг сурталчлах гол үүрэг гүйцэтгэсэн
- Олон улсын талбар дээр эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад тэргүүлэх хувь нэмрээ оруулж байна.
- ЭЯГБХУТК, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахыг хориглох тухай Тунхаглал /1993/, Бээжингийн Тунхаглал, Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр зэрэг нь эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, хангахад томоохон ахиц гаргасан баримт бичгүүд юмаа.

## Дөрөв. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАНГАХ СУУРЬ ЗАРЧИМ БА КОНЦЕПЦ

### 1. Төр ба хувийн хэвшлийн ялгаа ба хамаарал

*А. Төр.* Олон улсын, бүсийн болон үндэсний түвшинд тогтоосон хүний эрхийн стандарт, дүрмийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэхийг төрийн бүх шатны байгууллага, ажилтнуудаас шаарддаг. Ж/нь, эрүү шүүлт тулгах, эрүүдэн шүүх, дур мэдэн баривчлах зэргийг оруулаад,

80,90-ээд онд хүчээ авсан эмэгтэйчүүдийн хөдөлгөөн

одоог хүртэл охид, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө төрийн гүйцэтгэж байгаа үүрэг, хариуцлагад сэтгэл хангалуун байдаггүй.

Ж/нь: Ялгаварлан гадуурхалт, хэвшмэл ойлголт, зан заншил, эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх

*Б. Хувийн хэвшил.* Хүний эрхийг хамгаалах болоод эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхийг бүх хувийн хэвшлийн байгууллагууд мөрдөх ёстой. Энэ нь тухайн улс орны хүлээсэн үүрэгтэй шууд холбогдоно.

### **2. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрх ба үл ялгаварлан гадуурхах**

- ЭЯГБХУТК-ийн заалтууд болон хэрэгжүүлэх механизмууд нь үүнд шууд утгатай хамаарна.
- Эрэгтэй, эмэгтэйчүүдийн ялгаатай байдлаас шалтгаалан ялгаварлан гадуурхагдаж байгааг үүнд онцолсон.
- Охид, эмэгтэйчүүдэд ашиг тус багатай илүү хохирол учруулахаар Ялгавралани гадуурхалт нь Олон улсын гэрээнүүд болон хууль тогтоомжийг зөрчиж байна гэж үзэх үндэстэй. Ж нь, өнгө зүс, өндөр нам, нас, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, ажил мэргэжил гэх мэт ялгаварлан гадуурхалтын олон жишээ бий.
- De-jure – шууд ялгаварлан гадуурхалт /ажил хийхгүй, жолоо барьж болохгүй, өмчлөхгүй гэх мэт/
- De facto – шууд бус ялгаварлан гадуурхалт /зээл хэнд илүү олгож байна? өмчийн хэдэн хувь нь эмэгтэйчүүдийнх байна вэ ? гэх мэт/

### **3. Тэгш эрх ба тэгш боломж**

- Хүний хувьд эсвэл жендэрийнхээ хувьд эрх тэгш байх тухай ойлголт
- Тэгш эрх нь хүний эрхийн стандарт. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн бодит тэгш эрхийн тухай асуудал юм. Өөрөөр хэлвэл тэдний нийгэмд гүйцэтгэх

үүрэг, оролцоо хэрхэн ямар байгаад “шударга хандах” тухай асуудал. Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын хүрээнд хэрхэн бодит эрхээ эдэлж байна гэдгийг тодорхойлох зарчим юм.

- Тэгш боломж нь сурах, хөдөлмөрлөх гээд олон асуудалд тэгш боломжоор хангагдаж байна уу? Эмэгтэйчүүд сурах идэвхи сайн гэвч суралцагсдын ихэнх хувийг эзэлж байгаа нь эрэгтэйчүүдийн сурах боломжийг хааж байгаа юу?

### **4. Жендэр**

- Хүйс бол биологийн, Харин жендэр бол нийгмийн тухай ойлголт
- Эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн үүргийн талаарх уламжлалт ойлголт өөрчлөгдсөн. Одоо хөгжил, эрх мэдлийн талаар ярьдаг болсон.
- Эмэгтэйчүүдийн хувьд өөрийнхөө амьдралыг өөрөө эрх мэдэлтэйгээр залах тухай асуудал. Юу хийх, хэн байх, гэрлэх, хэдэн хүүхэд төрүүлэх нь эмэгтэйчүүдийн өөрийнх нь шийдвэр байх явдал үүнд чухалчилж байгаа.
- Жендэрийг бодлогод тусгаж хэрэгжүүлэх

### **5. Давхар ялгаварлан гадуурхалтын хэлбэрүүд болон харилцан хамаарал /intersectionality/**

Жишээ нь, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ихэнхдээ ядуу, ажилгүй, орлого багатай, орон гэргүй, эрүүл мэнд,



хүнс, хоол тэжээлийн дутагдал, хүчирхийлэлд өртөх магадлал өндөр. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ээжүүд мөн ялгаагүй байдаг. Үүнийг анхаарахыг улс орнуудад үүрэг болгож байгаа. Ер нь ядуу гэдэг дотор маш олон Хүний эрхийн анхдагч хэрэгцээ алдагдаад давхар давхар өртөөд байгааг ингэж тайлбарлаж байгаа.

### Тав. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ЭРХ ПРАКТИК ДЭЭР

#### 1. Улс төр болон нийгмийн амьдрал дахь эмэгтэйчүүдийн эрх

Түүхэндээ эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо ихээхэн бэрхшээл дагуулсаар ирсэн. Сонгож болно. Сонгогдож болохгүй гэдэг заалт зарим улс орнуудад одоог хүртэл байсаар байна.

Эмэгтэйчүүд улс төр, нийгмийн амьдралд шийдвэр гаргах эрхтэй оролцох нь 1. Тэгш эрхийн зарчимд нийцнэ. 2. өөрт хамаарах асуудлаа өөрсдөө шийдэж чадна. 3. Олж авсан туршлага, мэдлэг нийгэмд хувь нэмэр болно гэх мэт.

Иргэншлийн асуудал энд яригдана.

- Оршин суух газраа сонгох,
- албан тушаал хаших, байгууллага байгуулах,
- Хүний эрх, Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалагчдыг

хамгаалах

Intersectionality- өөрийгөө тодорхойлох

- арьс өнгө
- бэлгийн чиг баримжаа
- жендэрийн илэрхийлэл
- үндэстэн, ястан
- хөгжлийн бэрхшээл

#### 2. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрх

Эмэгтэйчүүдийн бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд нь ялгаварлан гудуурхалтаас ангид байх бүх эрхэд хамаарна. Ж/нь: Шууд ба шууд бусаар холбоотой амьд явах эрх, эрүүл мэндээ хамгаалах эрх, хувийн нууцад хамаарах эрх, аюулгүй байх, эрүүдэн шүүхээс ангид байх эрх, боловсрол эзэмших эрх гээд нийтдээ 12 эрхийг НҮЭМ-дэд хамааруулж үздэг болсон.

- эмэгтэйчүүдийн бэлгийн амьдрал руу гүн гүнзгий өнгийж хардаг
- гэрлэлт, жирэмслэлт, төрөлт, жирэмслэлтээс хамгаалах, үр хөндөлт, үргүйдлийн төлөө буруутгах хандлага
- нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, бараа, тоног төхөөрөмж
- бэлгийн цөөнхийн асуудал

## УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

- биеэ үнэлэлт
- бэлгийн хүчирхийлэл/хүчин
- БЗХӨ/ДОХ

### 3. Амжиргааны баталгаажих түвшинд хүрэх эмэгтэйчүүдийн эрх

Эмэгтэйчүүдийн амьдралын стандарт буюу зохистой амьдралын түвшин:

- хоол хүнс, ус, эрүүл ахуй, ариун цэвэр, хувцас, орон байраар хангагдах эрх,
- өмч хөрөнгө, газар эзэмших, ажил эрхлэх, өөрийн болон гэр бүлийнхэн, ялангуяа хүүхдийн өдөр тутмын хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай баталгаат амжиргаа
- Өрх толгойлсон эмэгтэйчүүдэд үзүүлэх дэмжлэг
- эмзэг бүлгийн эмэгтэйчүүдэд үзүүлэх амжиргааны баталгаа
- Салалтаас үүдэлтэй өмчийн асуудлууд
- Ахмад настан
- Ядуурал

### 4. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар олон жилийн урт хугацааны тэмцлийн үр дүнд 1992 онд ЭЯГБХУТК-ын Хороо Зөвлөмж гаргаж 1993 оны 12 сард болсон НҮБ-аас зохион байгуулсан Дэлхийн Бага хурлаар Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах

тухай ТУНХАГ бичиг батлагдснаар сая ХҮЧИРХИЙЛЭЛ гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Бүх улс оронд эмэгтэйчүүд амьдралынхаа бүх хүрээнд Хүчирхийлэлд өртөмтгий байдаг:

- статус, анги, нас, шашин шүтлэгээс бус
- гэртээ байгаа эсэх, ажил дээрээ, гудамжинд,
- зөрчилдөөний үед эсвэл хямралын үед
- охид, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл цагаач эмэгтэйчүүд,
- лесбиян, бисексуал, трансжендэр эмэгтэйчүүд

### 5. Эмэгтэйчүүд эрхээ эдлэхэд амьдрах газаргүй болох болон шилжилт хөдөлгөөн нөлөөлөх нь Эмэгтэй шилжигч нь дэлхийн шилжин суурьшигчдын тэн хагасыг бүрдүүлдэг.

- Ядуурлаас үүдэлтэй, аль эсвэл түрэмгийлэл, мөргөлдөөнөөс дайжих, газар нутгаа алдах зэргээс амжиргаа хөөж өөр нутагт шилжин суурьших, дүрвэхэд хүрч байна.
- Дүрвэх болон Шилжилт хөдөлгөөн нь аюулаас холдох сайн талтай ч амжиргааны баталгаа алдагддаг.
- Эмэгтэйчүүд ялгаварлан гадуурхалт, хөдөлмөрийн мөлжлөгт өртөх
- Хүчирхийлэл, дарамт шахалт
- Хоол хүнс тэжээлийн дутагдал
- Орон байрны асуудал

- Эрүүл мэнд
- Баримт бичиг
- Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд бүр хүнд тусдаг

## 6. Эмэгтэйчүүдийн хүний эрх дэх зөрчил болон хямрал

Зэвсэгт мөргөлдөөн, террорист халдлага, улс төрийн тэмцэл нь охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлийг нэмэгдүүлсээр байдаг. Үүнтэй тэмцэх дэлхий нийтийн хүчин чармайлт нэмэгдсэн хэдий ч:

- Бие махбодийн болон сэтгэл санааны хүчирхийлэл,
- Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн боолчлол,
- хулгайлах, хүн худалдаалах гэх мэт хүчирхийлэл
- олон нийтийн доромжлол, эрүү шүүлтийн үйлдлүүд, бүрмөсөн устгах
- Хүчирхийллийн хохирогч болж байгаа Хөвгүүд
- Бэлгийн хүчирхийлэл нь дайны гэмт хэрэг, хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэг гэж үздэг.
- Руандад Тутси омгийн эмэгтэйчүүдийг хүчиндэж зориудаар хомроглон устгасан хэрэгт ОУ-ын Эрүүгийн Шүүх ял оноосон. Югаславт Лалын шашинтай эмэгтэйчүүдийг бөөнөөр нь хорьж хүчирхийлж байсан.
- Манайд охидын эсрэг ДАЙН зарласан байна гэхээр байна.

## 7. Эмэгтэйчүүдийн төлөөх Шударга ёс

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл нь 1325 (2000 он) тогтоолдоо “Охид, эмэгтэйчүүдийн эрх бол онцгой юм” гэдгийг тодорхойлсон.

Энх тайван, аюулгүй байдал, хөгжлийн төлөө шударга ёсыг шаардах нь өөрөө эмэгтэйчүүдийн эрх юм.

Олон улсын Гэрээний үүрэг, хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах: Тухайлбал,

- Төр засаг, түүний харьяа албуудаас хүний эрхийн зохистой нөхцөлийг бий болгоход хамтын хүчин чармайлтыг өрнүүлэх
- Хүний эрхийн Комисс, Шүүх Засаглал, үр дүнтэй шийдвэрлүүлэх, эрх зүйн туслалцаа авах
- Эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, бие даасан байдлыг хангах
- Нийгмийн институцуудыг мэдлэгжүүлэх, стандартуудыг хэрэгжүүлэх
- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах хандлагатай хэвшмэл ойлголтууд, шашины үйл, зан заншлыг устгах

*Гуравдугаар бүлгийг Монфемнет Үндэсний сүлжээний сургалтын материал, онлайн мэдээллүүд, НҮБ-аас гаргасан материалуудад тулгуурлан МОНЭС-ийн зөвлөх Н.Чинчулуун боловсруулав.*

## УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

АШИГЛАЛТЫН ХУЧИН ТӨГӨЛДӨР ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОО, *ашигт малтмалын төрлөөр, 2020.1.31*

	Ашиглалтын тусгай зөвшөөрөл		Талбайн хэмжээ	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>БҮГД</b>	<b>1677</b>	<b>100%</b>	<b>1,639,459.4</b>	<b>100%</b>
Алт (шороо)	534	31.8%	236,815.0	14.4%
Нүүрс	300	17.9%	794,154.0	48.4%
Жонш	188	11.2%	29,857.5	1.8%
Шохойн чулуу	77	4.6%	43,868.4	2.7%
Төмөр	70	4.2%	41,721.9	2.5%
Түгээмэл, Хайрга, Элс	70	4.2%	3,685.1	0.2%
Түгээмэл, Шавар	53	3.2%	2,802.1	0.2%
Түгээмэл, Дайрга	34	2.0%	9,240.3	0.6%
Гянтболд	29	1.7%	9,062.1	0.6%
Түгээмэл, Элс	24	1.4%	1,333.4	0.1%
Холимог металл	23	1.4%	26,976.6	1.6%
Гөлтгөнө	22	1.3%	6,016.5	0.4%
Зэс	16	1.0%	80,534.3	4.9%
Алт (шороо), Зэс	14	0.8%	86,764.3	5.3%
Цагаан тугалга	13	0.8%	6,610.7	0.4%
Ховор металл	9	0.5%	7,435.4	0.5%
Зэс, Молибден	8	0.5%	14,328.3	0.9%
Элсэн чулуу, Түгээмэл	8	0.5%	1,553.5	0.1%
Уран	7	0.4%	76,866.1	4.7%
Молибден	7	0.4%	8,922.5	0.5%
Гантиг	7	0.4%	2,020.0	0.1%
Бал чулуу	6	0.4%	19,836.7	1.2%
Молибден, Гянтболд	5	0.3%	5,047.1	0.3%
Дайрга	5	0.3%	1,698.9	0.1%
Төмөр, Цайр	5	0.3%	1,126.4	0.1%
Манган	4	0.2%	7,507.0	0.5%
Зэс, Алт	4	0.2%	5,367.5	0.3%
Гянтболд, Цагаан тугалга	4	0.2%	2,833.9	0.2%
Мөсөн шүү	4	0.2%	1,449.0	0.1%
Мөнгө	4	0.2%	1,050.4	0.1%
Алт (шороо), Мөнгө	3	0.2%	9,587.7	0.6%
Хөнгөн цагаан	3	0.2%	1,370.9	0.1%
Бусад	117	7.0%	92,016.1	5.6%

Эх сурвалж: Кадастрын хэлтэс, АМГТТ



## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

# МАНЛАЙЛАГЧДЫН ТҮҮХ

- Дорноговь аймгийн Айраг сумын Найд багийн малчин
- Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Тост багийн ногоочин
- Завхан аймгийн Дөрвөлжин сумын Цогт баг



Эмэгтэйчүүд  
хамтгаа чагна

**Дорноговь аймгийн Айраг сумын  
малчин Б.Амгаланбаяр:**

## **ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ БОЛ ЗӨВХӨН НЭГ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ БИШ НИЙТИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ ЮМ.**

Дорноговь аймгийн Айраг сумын Нард багийн нутаг дахь Цагаан дэлийн агуй нь Монголын хамгийн урт, хамгийн том агуй байдаг. Гэтэл тус агуйн орчим жоншны орд байдаг учраас жонш олборлох, баяжуулах 10 гаруй ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий компаниуд ажиллаж, тэдгээр нь зэрэг зэрэг тэсэлгээ, тээвэрлэлт хийснээр тус агуйн унаган тогтоц эвдэгдэн дарагдах аюул нүүрлээд буй.

Уул уурхайн компаниудын тэсэлгээ, олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа нь 2010 оноос орчны 10 гаран өрхийн 100 шахам хүн ам, зургаан мянга гаран мал уух уусгүй, малаа бэлчээх бэлчээргүй болж, 2019 оны 10 сарын 01 ний дотор нүүх шахалт үзүүлж эхэлсэн.

Цагаан дэлийн орчим манай өвөө, эмээ үе дамжин амьдарч ирсэн. Ээж маань уул уурхайн компаниудын хууль бус үйл ажиллагаа, сөрөгнөлөөллийн талаар сум орон нутгийн удирдлагууд, холбогдох хүмүүст маш их асуудлыг тавьдаг, өргөдөл гомдол гаргаж, нутаг орныхоо төлөө тэмцэгч байсан. Тэр үед ээж яах гэж ингэж явдаг байна, болимоор юм гэж боддог байсансан. Ээж маань удаан тэмцсэний үр дүнд 2013-2015 онд уурхайн үйл

ажиллагаагаа түр зогсоож чадсан. Ээж маань 2016 онд, удалгүй мөн аав маань уул уурхайн тэсэлгээний улмаас цочиж, зүрх нь дэлсдэг болсны улмаас бие муудаж нас барсан.

Анх уул уурхайтай тэмцэж эхлэхэд надад туслах хүмүүс ховор, миний нэр хүндийг гутаан доромжилдог байсан. Хүний эрхийн сургалтад удаа дараалан сууж, сумынхаа уул уурхайн асуудлыг гаргаж тавьдаг, үгээ хэлдэг, тэмцдэг хүмүүстэй нийлж, төр засагт өргөдөл гомдол гаргах, яамдын хүмүүстэй уулзаж, асуудлаа ойлгуулж төрд нөлөөлж эхэлсэн.

Бидний хамгийн том амжилт бол

- Цагаан дэлийн агуйгаа улсын тусгай хамгаалалтад авч чадсан явдал юм.
- ХҮЭК-ийн дарга Ж.Бямбадоржоор ахлуулсан багийг сумандаа 2019.01 сарын 14 ний өдөр ирж, иргэд бид нартай уулзаад, ирүүлж Цагаан дэлийн агуйн нөхцөл байдлыг танилцуулсан.
- 2019 оны 5-р сарын 15-19 хооронд Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан, Говьсүмбэр

## УУЛ УУРХАЙ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

аймгийн Шивээговь сумын иргэд бид Өмнөговь аймгийн уул уурхайтай сумдын ИТХ, засаг захиргаа болон Оюу толгой, Энержиресоурс зэрэг томоохон уурхайн үйл ажиллагаатай танилцаж, компаниудын нөлөөллийн бүсийг хэрхэн тогтоож, хүний эрхийг хамгаалах нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор, нийгмийн хариуцлагын жишиг бодлого, үйл ажиллагаатай танилцаж компаний нийгмийн хариуцлага, бизнесийн үүргийн талаар мэдээлэлтэй болсон.

- 2019 оны 10-р сард Ирландын Дублин хотноо болсон дэлхийн малчин, хүний эрхийн хамгаалагч эмэгтэйчүүдийн чуулганд оролцож эмэгтэйчүүд бид ямар их хүчтэй, эрх мэдэлтэй бизнесийн бүлэгтэй тэмцэж байгаагаа ойлгосон. Зарим талаар эрсдэлтэй ч бид тэмцэхгүй бол ирээдүй үеийнхэний эрх, эрх чөлөө, нүүдэлчин зан заншил, соёл уламжлалаа устахыг хараад суух боломжгүй юм гэдгээ ойлгож авсан. Бид шантрахгүй эрх ашгийнхаа төлөө сайн санаат хүмүүстэй нэгдэж хамгаалах болно.



**Өмнөговь аймгийн Гурвантэс сумын  
ногоочин Л.Сүрэнхүү:**

## **НУТГИЙН ИРГЭН БҮРИЙН ДЭМЖЛЭГ, ӨӨРИЙН ТУУШТАЙ ЧИН СЭТГЭЛ БАЙХАД БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АЖИЛ БУЯНТАЙ АЖИЛ ШҮҮ.**

Гурвантэс сум нь улсын нийслэлээс 1000 гаран км-т оршдог. Тус сумын Тост багийн нутагт Улсын Тусгай Хамгаалалттай Тост Тосон бумбын нуруу байдаг газар. Гэтэл энд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдөр буюу 2017. 03.08 ны гэнэт, ямар ч мэдээлэл өгөлгүйгээр Сауд гоби коул транс ХХК кемпээ барьж эхэлсэн байна.

Тост багийн иргэн, Хуршуутын голын ногоочдын нөхөрлөлийн ахлагч Л.Сүрэнхүү нутгийн иргэдийн тахиж шүтдэг хайрханаа эрсдэлд орж байгаад сэтгэлээ чилээж нутгийн иргэдийн хамт сумын ЗДТГ, ИТХ-аас эхлээд аймгийн холбогдох төрийн байгууллагуудад улмаар яам агентлаг, Засгийн газар, УИХ –д хүртэл маш олон удаагийн захидал, өргөдөл, гомдол, албан хүсэлт, гарын үсэг цуглуулж хүргүүлсээр байсан ч хэрэгцээтэй мэдээллээ олж авч чадаагүйн дээр ямар ч нааштай шийдэл, хариу аваагүй байна. Зөвхөн Сауд гоби коул транс ХХК-н БОННУ-ний тайланг олж үзэхийн тулд 10 гаран албан хүсэлт хүргүүлж бүтэн 9 сарын дараа сая хуурамч үнэлгээ хийлгэсэн болохыг олж мэдэж байсан байдаг. Нэгэнт хуурамч, хууль бүс БОННУ батлуулж ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан болохыг тогтоосон тул Захиргааны хэргийн шүүхэд 2018.09 сард нэхэмжлэл гаргасан бөгөөд Захиргааны анхан шатны шүүхийн журмаар урьдчилсан хэлэлцүүлэг,

анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаа олон дахин хойшилсноор сумаасаа шүүх ажиллагаанд оролцохын тулд нийт 28 удаа нийслэлд ирсэн байна.

Авсан гол сургамжаа тэрээр 2008 оноос хойш иргэдийн хоршоо, бүлэг, компани байгуулж ажиллаж байсан ч эдгээрийн алинд ч байгаль хамгаалах эрх зүйн боломж бага тул “Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөл” байгуулах нь зөв гэдгийг олж авсан бөгөөд өнөөдөр 8 нөхөрлөлийн 200 гаран өрхийн 1700 шахам малчид, ногоочид нэгдэн “Тэсийн ирээдүй ТББ” байгуулан ажиллаж байна. Хамтын хүч хамгийн агуу, хамтын зүтгэл, хамт олны дэмжлэг, нутгийн хүмүүсийн тэр дундаа байгаль нутагтаа сэтгэлтэй нэг ч гэлтгүй хүмүүсийн дэмжлэг мөнгөөр хэмжишгүй их хүч гэдгийг олж мэдсэн байна.

Л.Сүрэнхүү маань маш урт хугацаанд шүүхийн журмаар асуудал шийдэхдээ өөрийн тэтгэврийн 5 сая төгрөгийн зээл хийж ажлаа эхлүүлж байсан тууштай тэмцэгч юм. 2019 онд ОУ-ын Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн шагнал хүртсэн бөгөөд түүний дагалдах гурван сая төгрөгийн шагналаараа “Тэсийн ирээдүй ТББ”-даа нэг ажилтан авч НДШ-ийг төлөхөд зарцуулж байгаагаа бахархалтайгаар ярьсан юм.



## Завхан аймгийн Дөрвөлжин сумын Цогт багийнхан Баянайраг ХХК-тай хамтран ажилласан туршлага

Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт 2014 оноос алтны уурхайн төсөл хэрэгжиж эхлэхээс нутгийн малчид, газар нутгаа хамгаалах чиглэлээр иргэд тасралтгүй 4 жил Баян Айраг ХХК-тай тэмцэж ирсэн.

Багийн малчид удаа шаардлага хүргүүлэн жагсаж, газар нутгаасаа явахыг шаардаж, хүн бүр өөр өөрийн хүссэн шаардлага тавьсаар байсан боловч ойлголцол бий болохгүй, үр дүн гарахгүй байсан байна. Багийн нийт иргэд, малчид хэсэг хугацааны дараа эрх ашгаа нэгдэж хамгаалж байгаа мэт боловч нэгэнт 30 жил ажиллах эрхээ авсан компанийн зүгээс хуулийн хүрээнд юу хүсээд байгаа, ямар алхам хийлгэх талаар багаараа нэгдсэн бодлого, хүлээлт байхгүй байгаагаа мэдсэн байна.

Иймд орон нутгийн хүний эрхийн ТББ, хуульчдаас зөвлөгөө авч “Тайх уулын Хишиг” нөхөрлөлийг багийн бүх иргэд, малчдын оролцоотой байгуулсанаар эрх зүйн хүрээнд компанитай хэлэлцэх, шаардлага тавих, хуулийн этгээдийн хувьд адил тэгш эрхтэй харилцах боломжийг нээсэн байна.

Баян-Айраг компани эхний ээлжинд “Тайх уулын Хишиг нөхөрлөл”-д 4 хово, 2 бонго, ажиллагсдыг зөөх автобус 2 ширхэгийг компанийн хөрөнгөөр авч өгөх, компани эдгээр техникээр төлбөрт үйлчилгээ авах талаар Хаитран ажиллах гэрээ хийсэн байна.

Малчдын нөхөрлөл нь тээвэр үйлчилгээнээс орсон орлогоосоо нөлөөллийн бүсийн иргэддээ өрх бүрт 300,0 төгрөгийг олгож ирсэн ба 2018 оноос тус багийн бүртгэлтэй иргэн бүрт сард 50,0 төгрөг олгохоор нөхөрлөлийн хурлаасаа шийдвэрлээд байна.

“Тайх уулын хишиг нөхөрлөл” нь Баян-Айраг ХХК-ийн түрээсээр авч өгсөн техникийн мөнгийг төлж дууссанаар нөхөрлөлийн хөрөнгө болсон байна.

Хамтран ажилах гэрээний зорилго нь тухайн уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүсэд байгаа иргэдэд Ашигт малтмалын тухай хуулийн 41-р зүйлийн 41.1 дэх хэсэгт заасан нөхөн олговор олгох харилцааг шийдэх зорилгыг агуулсан байна.

## Хавсралт 1.

Үйлдвэр, Худалдааны сайдын/хуучин нэрээр/ 2007 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 291 тоот, Уул уурхайн сайдын 2012 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн 32 тоот тушаалуудыг тус тус үндэслэн ашиглалтанд бэлэн болсон уурхай болон уулын үйлдвэрийг Улсын комисст хүлээлгэн өгөх хүсэлт гаргасан аж ахуйн нэгж дараах жагсаалтын дагуу бичиг баримтыг бүрдүүлнэ.

### Уурхай дээр байх ёстой бичиг баримтын жагсаалт

№	Бичиг баримтын нэрс
1	Аж ахуйн нэгжийн гэрчилгээ хуулбар
2	Ашиглалтын тусгай зөвшөөрөл
3	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр төлсөн баримт
4	Орд ашиглах ТЭЗҮ
5	Ашигт малтмалын нөөцийг улсын бүртгэлд авсан ЭБЗ-ийн хурлын протокол
6	Нөөц бодсон геологийн дэвсгэр зураг
7	Олборлолтын журнал
8	Ашиглалтын үеийн геологи, маркшейдерийн бичиг баримт

9	Сар, улирлын гүйцэтгэлийн мэдээ
10	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлсөн баримт
11	Төсвийн хөрөнгөөр хийгдсэн геологи хайгуулын зардлыг нөхөн төлөх гэрээ, төлбөрийн баримт
12	Ажлын нарядын дэвтэр
13	Аваар устгах төлөвлөгөө
14	Тэсэлгээний ажил явуулах зөвшөөрөл
15	Өрөмдлөг тэсэлгээний ажлын паспорт
16	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, сургалтын бүртгэл
17	Өнгөрсөн жилийн уулын ажлын гүйцэтгэл тайлан

18	Ашиглаж дууссан блок хаасан тухай акт
19	Технологийн баяжуулалтын алдагдал хаягдлыг өөрсдөө болон хяналтын байгууллагын тогтоосон тайлан, өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
20	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
21	БОНБНУ
22	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын 50%-г төлсөн, барьцаалсан баримт
23	Нөхөн сэргээлт хийсэн талбайг сум орон нутагт хүлээлгэн өгсөн акт
24	Газар ус ашиглах гэрээ болон төлбөр төлсөн тухай баримт

25	Уурхайн эдэлбэрийн шав тавиулсан тухай акт
26	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмчлөх эрхийг хөндсөн бүх төрлийн гэрээ хэлэлцэл
27	Тухайн орон нутгаас ажиллаж буй хүмүүсийн судалгаа
28	Урьд нь МХ байгууллагуудын улсын байцаагч нараас тавьсан албан шаардлага
29	Тухайн жилийн батлагдсан уулын ажлын төлөвлөгөө
30	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа
31	Орон нутгийн захиргаатай хамтран ажиллах гэрээ

## Шаардлагатай тогтоол шийдвэрүүдээс

	Дүрэм журмын жагсаалт	Тушаал шийдвэрийн дугаар	Эх сурвалж
1	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, аргачлал	Засгийн газрын 2013 оны 374-р тогтоол. хавсралт 2	<a href="https://www.legalinfo.mn/annex/details/6139?lawid=9681">https://www.legalinfo.mn/annex/details/6139?lawid=9681</a>
2	БОННУ-д иргэдийн оролцоог хангах журам	БОНХ-ийн сайдын 2014 оны А-03 тушаал	<a href="https://www.legalinfo.mn/annex/details/6169?lawid=9746">https://www.legalinfo.mn/annex/details/6169?lawid=9746</a>
3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаал	<a href="https://www.legalinfo.mn/annex/details/10262?lawid=14757">https://www.legalinfo.mn/annex/details/10262?lawid=14757</a>
4	Байгаль орчны нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт хяналт тавих, журам	БОНХ-ийн сайдын 2014 оны А-04 тушаал	<a href="https://www.legalinfo.mn/annex/details/6736?lawid=11025">https://www.legalinfo.mn/annex/details/6736?lawid=11025</a>
5	Хамтран ажиллах гэрээний загвар	Засгийн газрын 2016 оны 179-р тогтоол Засгийн газрын 2015 оны 430-р тогтоол	<a href="https://www.legalinfo.mn/annex/details/7245?lawid=11852">https://www.legalinfo.mn/annex/details/7245?lawid=11852</a> <a href="https://www.legalinfo.mn/annex/details/6956?lawid=11442">https://www.legalinfo.mn/annex/details/6956?lawid=11442</a>
6	ОУИТБС-ын дэд зөвлөлийн дүрэм, тогтоол	Засгийн газрын 2012 оны 222-р тогтоол	<a href="https://www.legalinfo.mn/annex/details/2187?lawid=5575">https://www.legalinfo.mn/annex/details/2187?lawid=5575</a>
7	Тусгай зөвшөөрөл олгох, сонгон шалгаруулах журам	УУХҮ-ийн сайдын 2018 оны А/28-р тушаал	<a href="http://www.mmhi.gov.mn/public/file/id/324">http://www.mmhi.gov.mn/public/file/id/324</a>

8	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам	Засгийн газрын 2017 оны 151-р тогтоол	<a href="https://www.legalinfo.mn/annex/details/7870?lawid=12681">https://www.legalinfo.mn/annex/details/7870?lawid=12681</a>
9	Ашигт малтмалын ордыг ашиглах лиценз эзэмшигч ААНБ-ын тухайн орд объект дээр байх ёстой бичиг баримтын жагсаалт	ГУУХА-ны даргын 1998 оны 15 тоот тушаал	<a href="https://www.mrpam.gov.mn/public/pages/135/29%20jagsaalt.pdf">https://www.mrpam.gov.mn/public/pages/135/29%20jagsaalt.pdf</a>
	Баяжуулах, боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардлагатай бичиг баримтын бүрдэл	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/16 дугаар тушаалын гуравдугаар хавсралт	<a href="https://www.legalinfo.mn/annex/details/9375?lawid=14119">https://www.legalinfo.mn/annex/details/9375?lawid=14119</a>
11	УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны дүрэм	УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны 2015 оны 01-р тогтоол	

**Уул уурхайн салбарын болон тухайлсан нэг ААНБ-ын талаар мэдээлэл авах хаягууд:**

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага - [e-reporting.eitimongolia.mn](http://e-reporting.eitimongolia.mn)
2. Хуулийн эдгээдийн улсын бүртгэлийн лавлагаа мэдээлэл - <http://opendata.burtgel.gov.mn/>
3. Хөрөнгө орлогын мэдээлэл, өнлөр албан тушаалтан, лиценз багц мэдээлэл - <http://www.opendatalab.mn/>
4. Олборлох салдар дахь бүх төрлийн гэрээний мэдээлэл- [www.iltodgeree.mn](http://www.iltodgeree.mn)
5. Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан - <https://eic.mn/>
6. Ашигт малтмал газрын тосны газар - <https://mrpam.gov.mn/>
7. Байгаль орчин, аялал жуулчлалын яам - <http://www.mne.mn/>
8. Уул уурхай хүнд үйлдвэрийн яам - <http://www.mmhi.gov.mn/>
9. Эрүүл мэндийн яам - <https://www.mohs.mn/>
10. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар - <http://inspection.gov.mn/>
11. Аудитын ерөнхий газар - <https://www.audit.mn/>

## ТЭМДЭГЛЭЛ

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

---

1. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”
2. Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого. 2014.
3. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого. 201-2026 он.
4. Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх удирдамж MNS ISO 26000:2012 стандарт
5. “Сайн туршлагыг авах нь” Уул уурхайн салбарын засаглалд хүрээлэн буй орчин ба хүний эрхийг нэгтгэх тухай Засгийн газар болон хамтрагч талуудад зориулсан гарын авлага. 2018 он. НҮБХХ
6. Иргэдийн үнэлгээний карт. 2011 он. Хил хязгааргүй алхам ТББ
7. Байгалийн баялгийн тунхаг. Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн
8. Уул уурхайн үйл ажиллагаанд холбогдох талуудын оролцоог хангах боломж. 2017
9. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) МУ-ын хууль зүйн мэдээллийн нэгдсэн систем
10. [www.mgam.gov.mn](http://www.mgam.gov.mn) Ашигт малтмал газрын тосны газар
11. [www.mne.mn](http://www.mne.mn) Байгаль орчин, аялал жуулчлалын яам